

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**“МӨРӨН ХОТЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮЖИЛТ,
ҮР ДҮН” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

**Мөрөн сумын хот тохижилт, үйлчилгээний бүх үйл ажиллагааг
зөвхөн хог хаягдлын хураамжийн орлогоор санхүүжүүлж байна**

АУДИТЫН КОД: : ХӨА-2023/47-ШТА-ГА

**Хөвсгөл аймаг
2023 он**

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: З.Даваадорж

Утас: 91890258 Цахим хаяг: Davaadoriz@audit.gov.mn

Аудитор: Н.Гүрбазар

Утас: 99979050 Цахим хаяг: Gurbazarn@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn

**Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.**
https://audit.mn/?page_id=579

Аудитын тайлан баталгаажуулах тушаал	4-5
Аудитын зорилт:	6
Аудитын хамарсан хүрээ:	6
Аудитын арга зүй:	6
Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:	7
Аудитын хязгаарлалт:	7
Аудитын ерөнхий мэдээлэл:	7
Бүлэг А. Компанийн одоогийн засаглал нь хот тохижилт, үйлчилгээний менежментийг сайжруулж, оновчтой тогтолцоог бүрдүүлж чадаагүй байна.	7
А.1. Хог хаягдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хянах тогтолцоо алдагдсан байна.	7 - 14
А.2. Компанийн үндсэн чиг үүрэгт хамааралгүй, ашиглалтгүй эд хөрөнгийн элэгдэлд жилд 31.8 сая төгрөгийг хүлээн зөвшөөрч бүртгэж байна.	14 - 20
Бүлэг Б. Компанийн 2021-2023 онд зарцуулсан нийт зардал нь үндсэн болон туслах үйл ажиллагааны чанар болон ажлын бүтээмжийг дээшлүүлээгүй үр ашиггүй зардал болсон байна.	20
Б.1. Мөрөн сумын хот тохижилт, үйлчилгээний бүх үйл ажиллагааг зөвхөн хог хаягдлын хураамжийн орлогоор санхүүжүүлж байна.	20 - 22
Б.2. Компанийн 2021-2023 онд зарцуулсан нийт зардал нь үндсэн болон туслах үйл ажиллагааны чанар болон ажлын бүтээмжийг дээшлүүлээгүй үр ашиггүй зардал болсон байна.	23 - 31
Санхүүгийн тайлангийн шинжилгээ	32 - 33
Аудитын дүгнэлт	34
Аудитын зөвлөмж	35
Аудитын зөрчлийн нэгтгэл	36 - 37
Шалгагдагч байгууллагын санал	38 - 41
Хавсралт	42
Акт, албан шаардлага	43 - 48

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
БОАЖС	Байгал орчин аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгал орчин аялал жуулчлалын яам
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХАБ	Хөдөлмөрийн аюулгүй байдал
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман улс
БХӨТ	Богино хугацаат өр төлбөр
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

oooOOOooo



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2023 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 1/28

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2018 оны А/207 “Эрх үүрэг шилжүүлэх тухай” дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Мөрөн хотын тохижилт үйлчилгээний үйл ажиллагаа, санхүүжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аудитын тайланг аймгийн ИТХ, “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн ТУЗ, Мөрөн сумын засаг дарга, “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК, “Хөвсгөл Эрчим хүч” ХХК нарт тус тус хүргүүлсүгэй.

3. “Мөрөн хотын тохижилт үйлчилгээний үйл ажиллагаа, санхүүжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор багтаан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг дээрх байгууллагын дарга нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (З.Даваадорж)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер (Б.Тэгшдэлгэр)-т даалгасугай.

6. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2023 оны 09 дүгээр сарын 10-ний өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (З.Даваадорж)-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, Тэргүүлэх аудиторын 2023 оны 8 дугаар
сарын 14-ны өдрийн 14/ХТ-2023/08 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

“МӨРӨН ХОТЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА,
САНХҮҮЖИЛТ, ҮР ДҮН” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТААР ӨГСӨН АКТ,
АЛБАН ШААРДЛАГ ҮН ЖАГСААЛТ

№	Албан шаардлагын дугаар	Утга
1	58/A2270469/ХӨА-2023/47-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай
2	59/A2270469/ХӨА-2023/47-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай
3	60/A2270469/ХӨА-2023/47-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай
4	89/A2270469/ХӨА-2023/47-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай
5	90/A2270469/ХӨА-2023/47-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай
6	91/A2270469/ХӨА-2023/47-ШТА-ГА	Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл:

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Монгол улсын Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны “Аудитын сэдэв батлах тухай” 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/04 дугаар тушаалаар баталсан аудитын сэдвийг үндэслэн “Мөрөн хотын тохижилт үйлчилгээний үйл ажиллагаа, санхүүжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитыг хийлээ.

Аудитын зорилт:

“Мөрөн хотын тохижилт үйлчилгээний үйл ажиллагаа, санхүүжилт, үр дүн”-нд Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Мөрөн сумын Засаг дарга, “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв”ХХК болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- ❖ “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн тогтолцоо, үйл ажиллагаа үр дүнтэй байгаа эсэх,
- ❖ “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК нь санхүүжилтийг үр дүн, үр ашигтай зарцуулсан эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг Мөрөн сумын Засаг даргын Тамгын газар, “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн 2021-2022 он, 2023 оны хагас жилийн үйл ажиллагаа, Мөрөн суманд 2021-2023 онд хэрэгжсэн олон улсын зээл тусламж, төсөл хөтөлбөрийн үр дүн болон “Хөвсгөл Эрчим хүч” ХХК-ийн 2022-2023 оны хог хаягдлын хураамжийн орлогыг хамруулан гүйцэтгэв.

Шүүхийн шийдвэртэй, хууль хяналтын байгууллагад шалгагдаж буй асуудлыг аудитад хамруулаагүй болно.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 300, 3000-3100, 5400-5499, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудитын Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” MNS 6817-7:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал” зэргийг баримтлан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, баримтад дурдсан мэдээлэлд шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашигласан.

Мөрөн хотын тохижилт үйлчилгээний үйл ажиллагаа, санхүүжилтийг төлөвлөх, санхүүжүүлэх, тайлагнах, хяналт тавихтай холбоотой хууль, эрх зүйн актыг судлах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, мэдээлэл, тодруулга авах, асуудал эрхэлсэн байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, судалгаа, тайланг судалж, дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор З.Даваадорж, аудитор Н.Гүрбазар, Г.Ичинхорлоо нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хязгаарлалт:

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн захиргаа аж ахуйн албан хаагчид, гүйцэтгэх удирдлага удаа дараа солигдсон байгаа нь аудитад шаардагдах баримт, материалыг олохгүй байх, бүрдүүлж ажиллаагүй байх зэрэг хязгаарлалт үүсгэсэн.

Ерөнхий мэдээлэл:

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК нь 2008 онд Мөрөн сумын ИТХ-ын 55 дугаар тогтоолоор байгуулагдаж Мөрөн сумын дэргэд төсөвт байгууллагын хэлбэрээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. Аймгийн ИТХ-ын 2019 оны 15 дугаар тогтоолоор тус оны 02 дугаар сарын 01-ний өдрөөр тасалбар болгон орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон зохион байгуулалтын хэлбэрийг өөрчилж дүрмийг шинэчлэн баталжээ.

Компанийн үйл ажиллагааны 2021 оны нийт орлогыг 1,126.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,390.0 сая төгрөгөөр тооцож баталсан бол 2022 оны нийт орлогыг 1,577.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,577.1 сая төгрөгөөр тооцож баталсан байна.

Гүйцэтгэлээр 2021 онд борлуулалтын орлого нь 1,195.4 сая төгрөг, нийт зардал 1,582.2 сая төгрөг буюу 386.8 сая төгрөгийн алдагдалтай, 2022 онд борлуулалтын орлого 1,807.2 сая төгрөг, нийт зардал 2,042.9 сая төгрөг буюу 235.6 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Тус компанийн 2021 оны санхүүгийн тайланд “Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар”, 2022 оны санхүүгийн тайланд “Ихэрмөрөн - Аудит” ХХК тус тус аудит хийж өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн байна.

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК нь 2021 онд нягтлан бодох бүртгэлдээ Санхүүгийн тооцоолох төвийн Ахplorer программ ашиглаж байгаад аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу 2022 онд санхүүгийн программаа шинэчлэн Smartlogic компанийн Smart программыг 7.3 сая төгрөгөөр худалдан авч нягтлан бодох бүртгэлээ хөтөлж байна.

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн 2023 оны хагас жилийн байдлаар үндсэн хөрөнгийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Хүснэгт №1 /сая.төг/

№	Хөрөнгийн төрөл	Хөрөнгийн анхны өртөг	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Барилга байгууламж	684.6	135.1	549.5
2	Тээврийн хэрэгсэл	1,766.2	858.6	873.3
3	Газар	2,560.3	-	2,560.3
4	Тавилга эд хогшил	6.1	5.7	0.4
5	Тоног төхөөрөмж	120.0	93.3	26.7
6	Нийтийн эзэмшлийн	1,858.1	884.1	751.6
7	Программ хангамж	11.9	3.9	8.0
8	Чулууны үйлдвэрийн хөрөнгө	150.0	84.0	65.9
Нийт дүн		7,157.2	2,064.8	4,835.7

Компани нь 2022 жилийн эцсийн байдлаар 7,157,2 сая төгрөгийн хөрөнгөтэй байгаа бөгөөд 2019-2022 онд улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2,693.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

БҮЛЭГ А:

КОМПАНИЙН ОДООГИЙН ЗАСАГЛАЛ НЬ ХОТ ТОХИЖИЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛЖ, ОНОВЧТОЙ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ ЧАДААГҮЙ БАЙНА.

А.1. Хог хаягдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хянах тогтолцоо алдагдсан байна.

А.1.1. Мөрөн хот тохижуулах үйлчилгээний төв нь аймаг, орон нутгийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан үйл ажиллагааг гүйцэтгэж байна.

Иргэд, оршин суугчдын цэвэр, эрүүл аюулгүй тохитой орчинд амьдрах хэрэгцээ шаардлагад тулгуурлан аймаг, сумын ИТХ, засаг даргаас дараах урт болон дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Аймгийн ИТХ-аас “Хөгжсөн Хөвсгөл 2016-2030” зэрэг дунд, урт хугацааны хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэн.
2. Мөрөн сумын ИТХ-аас “Мөрөн сум (хот)-ын дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр 2013-2023” батлан хэрэгжүүлсэн.
3. Мөрөн сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хоггүй-Мөрөн сумын хог хаягдлын менежментийг сайжруулах” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

Аймаг, сумын урт, дунд хугацааны бодлого зорилтод тусгагдсан арга хэмжээ болон компанийн эрхэлж буй үйл ажиллагааг харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт №2

№	Бодлого, зорилтод тусгагдсан арга хэмжээ	Компанийн эрхэлж буй үйл ажиллагаа	Үр дүн
“Хөгжсөн Хөвсгөл 2016-2030”			
1	Хатуу хог хаягдлыг ангилан, дахин боловсруулах, цуглуулах, тээвэрлэх эргүүлэх ашиглах, ашиглах, байгальд ээлтэй аргаар устгах механизмыг хэрэгжүүлэх	Мөрөн сумын айл, өрх, байгууллага аж ахуйн нэгжийн хог хаягдлыг зайлуулах	2021 онд 38,379.0 тн, 2022 онд 20,537.2 тн, 2023 оны хагас жилд 20,989 тн хог, хаягдал тээвэрлэж, булшилсан байна.
2	Хог хаягдлыг бууруулах, боловсруулах үйлдвэрлэл үйлчилгээг дэмжин хог хаягдлын менежментийг сайжруулах	Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээг авч байгаа 2022-2023.	Бодлогын баримт бичиг эцэслэн гараагүй байна.
3	Хогийн төвлөрсөн цэгийн байгальд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулж, аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэгт ландфилл технологийг нэвтрүүлэх	Төвлөрсөн хогийн цэгийг түрж ажлыг зохион байгуулж байна.	2021 онд 38,379.0 тн, 2022 онд 20,537.2 тн, 2023 оны хагас жилд 20,989 тн хог, хаягдал тээвэрлэж, булшилсан байна.
4	Хууль журмын дагуу аюултай хог хаягдлыг устгах болон шаардлагатай арга хэмжээг тухай бүрд хэрэгжүүлэх	Дүрэмд тусгагдаагүй.	Хууль, журамд заасны дагуу үүсгэгч нь түр /90-180 хоног/ хадгалж устгадаг
Мөрөн сум (хот)-ын дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр 2013-2023			
1	Хог хаягдлын нэгдсэн цэгийг орчин үеийн стандартын аргаар нөхөн сэргээх	Ландфилл технологийг нэвтрүүлэхээр зорьж байгаа.	Зураг, төсөв хийгдэж байгаа. Урьдчилсан байдлаар 14.0 тэрбум төгрөг төсөвт өртөгтэй гэсэн дүн гарсан байна.
2	Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах, эх үүсвэр дээр нь ангилан ялгах	Хог хаягдлыг зөөж хаяж буй жолооч нар хуванцар, цаас, шилийг дахивар авах цэгт өгдөг.	Түүхий эд нь үйлдвэрлэлээ хангаж чадахгүй байгаа талаар зөвлөх үйлчилгээний баг урьдчилан байдлаар танилцуулсан байна.
3	Иргэдэд сургалт сурталчилгаа явуулах, чиг хандлагыг өөрчлөх арга хэмжээг үе шаттай зохион байгуулах	2022 онд "Өөрсдөөсөө эхэлье" аян зохион байгуулсан.	Айл, өрх, албан байгууллага, ЕБС хог хаягдлаа ангилан ялгаж тус аянд нэгдсэн.
Мөрөн сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр			
1	“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн авто парк шинэчлэх, нийтийн эзэмшлийн зам, талбайн цэвэрлэгээ, хог хаягдлыг ангилан	Компани өөрийн эх үүсвэрээр шийдвэрлээгүй. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн эх үүсвэрээр.	- 2019-2021 онуудад чингэлэгтэй машин нэмж ирсэн.

	ялгаж цуглуулж, тээвэрлэх оновчтой менежментийг хэрэгжүүлнэ.		- 2022 онд 2 машин шинээр ирсэн. 2017-2022 онуудад.
2	Хог хаягдлыг ангилан ялгаж чиглэлээр олон нийтийн хандлагыг өөрчлөх сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж, хог хаягдлыг бууруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	2022 онд "Өөрсдөөсөө эхэлье" аян зохион байгуулсан.	Айл, өрх, албан байгууллага, ЕБС хог хаягдлаа ангилан ялгаж тус аянд нэгдсэн.
3	Аюултай хог хаягдлыг бүртгэлжүүлж, ангилан ялгаж, тээвэрлэх түр хадгалах, устгах журмын хэрэгжилтийг хангаж ажиллана.	Дүрэмд тусгагдаагүй.	Хууль, журамд заасны дагуу үүсгэгч нь түр /90-180 хоног/ хадгалж устгадаг

Дээрх хүснэгтээс харьцуулан харахад урт, дунд хугацааны бодлого зорилтод тусгагдсан дараах ажлууд хэрэгжээгүй байна. **Үүнд:**

1. Ландфилл технологийг нэвтрүүлэх,
2. Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах

Дээрх 2 арга хэмжээ хэрэгжээгүй байгаа нь компанийн хөрөнгөөр барьж байгуулах боломж хязгаарлагдмал, аймаг орон нутгийн бодлогын түвшинд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэхүйц төсөвт өртөг ихтэй байгууламжууд байхаар урьдчилсан тооцоолол гарсан байна.

Компанийн дүрэм, үйл ажиллагаанаас үзэхэд Мөрөн сумын урт, дунд хугацааны бодлогын баримтад тусгагдсан зорилт, арга хэмжээг чиг үүргийн хүрээнд гүйцэтгэн ажиллаж байна.

А.1.2. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн хэтийн зорилтыг тодорхойлох стратеги төлөвлөгөөг батлаагүй байна.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 15 дугаар тогтоолоор Хот тохижуулах үйлчилгээний төв улсын төсөвт үйлдвэрийн газрыг тухайн оны 02 дугаар сарын 01-ний өдрөөр тасалбар болгон “Мөрөн хот тохижилт, үйлчилгээний төв” орон нутгийн өмчит ХХК болгон зохион байгуулалтын хэлбэрийг өөрчилж тухайн тогтоолоор компанийн дүрмийг баталсан байна.

Аймгийн ИТХ-аас 2019 онд баталсан дүрэмд стратеги төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх талаар тусгаагүй бөгөөд 2021 оны 126 дугаар тогтоолоор баталсан дүрэмд компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхэд “Стратегийн зорилтуудыг тодорхойлж, урт болон дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах” гэж заасан байна.

“Мөрөн хот тохижилт, үйлчилгээний төв” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь 2022, 2023 оны хурлаар дүрэмд заасан “стратегийн зорилтуудыг тодорхойлж, урт болон дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах” талаар хэлэлцээгүй бөгөөд гүйцэтгэх удирдлагаас стратеги төлөвлөгөөг боловсруулан хэлэлцүүлэхээр санал оруулаагүй байна.

Компанийн стратегийн зорилтуудыг тодорхойлж, урт болон дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулаагүй нь тухайн компанийн үндсэн чиг үүргийг дүрмээс хасах, үр ашиггүй чиг үүргийг нэмснээр компанийн цаашид тогтвортой, алдагдалгүй ажиллахад сөрөг нөлөөтэй байна.

А.1.3. Компанийн бизнес төлөвлөгөөг бодит тооцоо, судалгаанд үндэслэн боловсруулаагүй байна.


Компанийн бизнес төлөвлөгөөг компанийн дүрэмд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан зорилтот түвшнийг үндэслэн баталж ирсэн байна.

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК нь даараах 2 төрлөөр бизнес төлөвлөгөөг боловсруулан хүргүүлж байна.

1. Төсвийн төслийг Мөрөн сумын Засаг даргад
2. Бизнес төлөвлөгөөг боловсруулан ТУЗ-д хүргүүлж байна.

Компанийн 2021, 2022, 2023 оны төлөвлөлтийг хамруулан үзэхэд 2021, 2022 оны зорилтод түвшнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан баримт материал байхгүй тул 2023 оны бизнес төлөвлөгөөг хамруулан үзэхэд дараах байдалтай байна.

График №1




Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Компанийн 2023 оны зорилтод түвшингээр компанийн бизнес төлөвлөгөөг баталсан боловч бизнес төлөвлөгөөнд тодотгол хийж 390.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөгөөр өөрийн үйл

ажиллагааны орлогоос 278.4 сая төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн бөгөөд орлого бүрдүүлэлтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар авч үзвэл дараах байдалтай байна.

График №2



Графикаас харахад 2023 оны орлого бүрдүүлэлт 67.9 сая төгрөг буюу гүйцэтгэл 24.4 хувьтай байгаа нь орлого бүрэн төвлөрөхгүй байх нөхцөл үүссэн байна.

Аудитын явцад хийсэн ярилцлагаар бизнес төлөвлөгөөг боловсруулахдаа орлогоос давсан зардлын хэмжээг орлогын төлөвлөгөөнд хийсвэрээр нэмж төлөвлөдөг, үүнээс шалтгаалан орлогын төлөвлөгөө биелэхгүй тасардаг гэж холбогдох ажилтнууд хэлсэн.

Мөн орлогыг нэр төрлөөр нь зөрүүлэн бүртгэж биелэлтийг алдаатай тайлагнаснаас дараа жилийн орлогын төлөвлөгөөг буруу төлөвлөдөг байдал харагдаж байна. /Орлогын төлөвлөгөөний биелэлттэй холбоотой зөрчлийг Б.2.2 дахь хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү/


Компанийн бизнес төлөвлөгөөнд орлогыг хийсвэрээр нэмэгдүүлж төлөвлөдөг, өмнөх оны гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнаснаас өмнөх жилүүдийн харьцуулсан шинжилгээ алдаатай хийгддэг, зорилтот түвшинд уялдуулахгүйгээр тооцоо хийж байгаагаас харахад бизнес төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөж байна.

А.1.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс компанийн хяналтын тогтолцоо алдагдсан байна.

Компанийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн хурал буюу аймгийн ИТХ-ын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байхаар хуульчилсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд ТУЗ нь 2021 он, 2022 он, 2023 оны эхний хагас жилийн байдлаар 14 удаа хуралдаж 34 шийдвэр гаргасан байна. Гаргасан шийдвэрийг ангилан авч үзвэл дараах байдалтай байна.

График № 3



Графикаас харахад бүтэц орон тоо, томилох чөлөөлөх, хороо байгуулах шийдвэр нь 50 гаруй хувийг эзэлж байгаа нь ТУЗ компанийг ашигтай ажиллуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллагаагүйг харуулж байна.

ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг байнгын, тогтмол, мэргэшсэн явуулах зорилгоор нэр дэвшүүлэх хороо, аудитын хороо, цалин урамшууллын зэрэг 3-н хороог байгуулсан боловч хороодын ажиллах журмыг баталж мөрдүүлээгүй байна.

Компанийн дүрмийн хэрэгжилт, ТУЗ-ын шийдвэр, үйл ажиллагаанд хяналт чиг үүрэг бүхий аудитын хорооны үйл ажиллагааг тухайн авч үзэхэд компанийн дүрмээр тодорхойлсон чиг үүргийг хэрэгжүүлээгүйгээс дараах үр дагавар үүссэн байна. Тухайлбал: Схем №2



ТУЗ нь компанийн үндсэн үйл ажиллагааг сайжруулах хүрээнд стратеги төлөвлөгөө зэрэг бодлого шийдвэр гаргаагүй, мөн компани дахь хяналтын тогтолцоог одоог болтол бүрэн бүрдүүлээгүй байна.

Аудитын хороодын ажиллах журмыг батлан мөрдүүлж хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэн хороодын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах нь зүйтэй байна.

А.1.5. Компани нь дүрэмд заасан үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг аймгийн ИТХ-ын 2021.12.30-ны өдрийн 126 дугаар тогтоолоор баталсан боловч дүрмийг Улсын бүртгэлд бүртгүүлээгүй байсныг аудитын явцад дүрмийг эрх бүхий байгууллагад бүртгүүлээ.

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийг аймгийн ИТХ-ын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 15 дугаар тогтоолоор баталсан дүрмээр 5 үндсэн үйл ажиллагаа гүйцэтгэхээр, 2021 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 126 дугаар тогтоолоор баталсан дүрмээр 10 үндсэн үйл ажиллагаа гүйцэтгэхээр тогтоосон байна. Компанийн гүйцэтгэх үндсэн үйл ажиллагааг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Хүснэгт № 3

№	Аймгийн ИТХ-ын 2019.01.30-ны өдрийн 15 дугаар тогтоолоор баталсан дүрмээр	Аймгийн ИТХ-ын 2021.12.30-ний өдрийн 126 дугаар тогтоолоор баталсан дүрмээр
1	Мөрөн сумын айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжийн хог хаягдал зайлуулах, төвлөрсөн хогийн цэгүүдийн үйл ажиллагааг эрхлэх ба хог хаягдлыг хөрсөөр дарж булах, ариутгах, халдваргүйжүүлэх, хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах	Мөрөн сумын айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжийн хог хаягдал зайлуулах
2	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайг угаах цэвэрлэх, хог хаягдлыг цуглуулах, ачиж тээвэрлэх, засварлах арчлах, нийтийн бие засах газрын ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах	Нийтийн эзэмшлийн гудамж талбай, авто замын арчилгаа, засварлалт, авто зам, талбайн хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх
3	Мөрөн хотын нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулах	Ногоон байгууламжийг нэмэгдүүлж, арчлах
4	Эзэнгүй муур, нохой устгах	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийг хариуцаж, засвар арчилгааг хийх
5	Хууль тогтоомжоор хориглоогүй бусад үйл ажиллагааг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хэрэгжүүлнэ.	Нийтийн эзэмшлийн талбай, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж, засварлах арчлах
6		Мөрөн хотын нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулах
7		Золбин нохой устгах
8		Байгалийн боржин чулуу, гантиг чулуу олборлох
9		Байгалийн чулуу боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх
10		Хууль тогтоомжоор хориглоогүй бусад үйл ажиллагааг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хэрэгжүүлнэ.

Компанийн дүрмээс зарим чиг үүргийг хасаж, зарим чиг үүргийг нэмсэн боловч дүрэмд заасан үндсэн чиг үүргийг гүйцэтгээгүй мөн дүрэмд заагаагүй чиг үүрэг гүйцэтгэснийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Хүснэгт № 4

№	2019.01.30-ны өдрийн 15 дугаар тогтоолоор баталсан дүрэм	2021.12.30-ний өдрийн 126 дугаар тогтоолоор баталсан дүрэм
Дүрэмд заасан боловч хэрэгжээгүй чиг үүрэг:		
1	Төвлөрсөн хогийн цэгийг ариутгах, халдваргүйжүүлэх, хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах	Байгалийн боржин чулуу, гантиг чулуу олборлох
2	Нийтийн бие засах газрын ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах	Байгалийн чулуу боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх
Дүрэмд заагаагүй боловч гүйцэтгэсэн ажил:		
1	Ногоон байгууламж, Хүүхдийн фарк, Хаяг реклам, Ус хүргэлт, Газар ашиглуулсны түрээс төвлөрүүлэх.	Төвлөрсөн хогийн цэгүүдийн үйл ажиллагааг эрхлэх ба хог хаягдлыг хөрсөөр дарж булах
2	Чулууны үйлдвэрийн үйл ажиллагаа	

Хүснэгтээс харахад дараах зөрчлүүд байна. Үүнд:

1. Мөрөн сумын төвлөрсөн хогийн цэгүүдийн үйл ажиллагааг эрхлэх ба хог хаягдлыг хөрсөөр дарж булах, ариутгах, халдваргүйжүүлэх, хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах гэсэн үндсэн чиг үүргийг хассан
2. Компанийн гүйцэтгэх үндсэн чиг үүргээс хасагдсан хэдий ч бизнес төлөвлөгөөндөө тусган Мөрөн сумын ЗДТГ-тай 2022 онд 23,689.5 тонн хог хаягдлыг түрж булсан үр дүн гарсан байхад
3. Дүрэмд заасан боржин, гантиг чулуу олборлох, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлээгүй байна.
4. Чулуу олборлох, боловсруулах үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдоогүй


Энэ нь компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны үйл ажиллагаа, хяналт хангалтгүй байгаагаас шалтгаалсан байна.

Компанийн нь иргэд, оршин суугчдын цэвэр, эрүүл аюулгүй тохитой орчныг бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх үндсэн чиг үүргийг дүрэмд нэмж тусгах, компаниас техник тоног төхөөрөмж хүний нөөц, тусгай зөвшөөрөл шаардсан “авто замын арчилгаа, засварлалт” зэрэг чиг үүргийг дүрмээс хасах нь зүйтэй байна.

А.1.6 Хог хаягдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хянах тогтолцоо алдагдсан байна.

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн засаглалын бүтцийг схемээр харуулав.

Схем №1



“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК нь 2019 оноос орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани статустай болсон хэдий ч санхүүжилтийн хувьд компанийн тогтолцоонд бүрэн шилжээгүй, 2 газарт санхүүжилт, үйл ажиллагааны төслийг хянуулж ажиллаж байна. Үүнийг диаграммаар харуулбал дараах байдалтай байна.

Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1¹, 9.4.1² дэх заалтуудад зааснаар аймгийн ИТХ нь хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, сумын засаг дарга нь хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй байдаг.

Гэтэл аймгийн ИТХ “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-г өөрийн өмчлөлд авчирснаар хяналтын чиг үүрэг нь алдагдаж, Мөрөн сумын Засаг дарга нутаг дэвсгэрийн хэмжээнд хог *Диаграмм №1* хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүргээ зөвхөн гэрээ байгуулах хэмжээгээр хязгаарлуулан, хот тохижилтын үйл ажиллагаанд удирдлагын түвшинд чиглэл өгөх эрхгүй болсон байна.

Хот тохижилт үйлчилгээний чиглэлээр адил төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа нийт 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн тогтолцооны хувьд харьцуулан үзэхэд дараах байдалтай байна.



Дээрх графикаас харахад Хөвсгөл аймгаас бусад аймгийн төвийн хот тохижилт, үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд нь сум, дүүргийн Засаг даргын дэргэд ОНӨААТҮГ болон төсвийн байгууллага хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Компанийн засаглалыг хэрэгжүүлж байгаа Төлөөлөн удирдах зөвлөл нь стратеги төлөвлөгөөг батлаагүй, бизнес төлөвлөгөөг үйл ажиллагаанд нь нийцүүлэн боловсруулсан эсэхэд хяналт хэрэгжүүлээгүй, ТУЗ-ийн дэргэд ажиллах хороод нь чиг үүргийн дагуу үр дүнтэй ажиллаагүй, гүйцэтгэх захирал болон компанийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй зэргээс харахад компанийн одоогийн засаглал нь хот тохижилт үйлчилгээний менежментийг сайжруулж, оновчтой тогтолцоог бүрдүүлж чадаагүй байна.

А.2. Компанийн үндсэн чиг үүрэгт хамааралгүй, ашиглалтгүй эд хөрөнгийн элэгдэлд жилд 41.6 сая төгрөгийн зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

А.2.1. Компанийн бүтэц, орон тоог 2021-2023 онд 4 удаа өөрчилсөн нь удирдлага, зохион байгуулалт хангалтгүй байгааг харуулж байна.

Компанийн бүтэц, зохион байгуулалт, орон тоог ТУЗ-ийн 2021 оны 01, 2021 оны 09, 2022 оны 10, 2023 оны 01 дүгээр тогтоолуудаар 4 өөрчилж ажилласан байна. Бүтэц, орон тооны 2021 - 2023 оны өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна:

Хүснэгт № 5

д/д	Бүтэц	Орон тоо			
		2021 он	2022 он	2022 он	2023 он
1	Захиргаа, аж ахуй	6	6	7	7
2	Хог хаягдал	39	37	35	39
3	Техник, тохижилт засвар, үйлчилгээ	10	10	-	-
4	Зам талбайн цэвэрлэгээ, арчилгаа	14	14	11	11
5	Ногоон байгууламж, төлөвлөлт, арчилгаа	21 /гэрээт 12/	17 /гэрээт 11/	11	12
6	Нийтийн тээвэр	10	10	13	13

¹ нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

² нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

7	Гэрэлтүүлэг	-	3	3	3
8	Нохой устгал	-	1	-	-
9	Хог түрж булах	-	1	-	-
Нийт		100 /үндсэн 88, гэрээт 12/	99 /үндсэн 88, гэрээт 11/	80	85

Хүснэгтээс харахад 4 удаагийн өөрчлөлтөөр техник, тохижилт үйлчилгээний хэсэг болон хог хаягдлын хэсгийн олон нийтийн байцаагчийн орон тооны өөрчлөлт дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд нийт орон тооны хязгаар 88-аас 85 болон буурсан байна. Бүтэц, орон тооны гол өөрчлөлтийг тоймловол:

1. Хог хаягдлын олон нийтийн байцаагчийн орон тоог 4-өөр бууруулж ачигчийн орон тоог 3-аар нэмэгдүүлсэн,
2. Зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээний үйлчлэгчийн орон тоог 3-аар бууруулж нийтийн эзэмшлийн эд хөрөнгө засах, үйлдвэр үйлчилгээний орон тоо 3-ийг бий болгосон,
3. “Хоймор нутгийн чулуу” ХХК-аас шилжин ирсэн техник үйлчилгээний хэсгийн чулуучин жолооч, болон чулуучин, гагнуурчин гэсэн 3 орон тоог үр ашиг багатай тул хассан,
4. Техник үйлчилгээний хэсгийг бүтцээс хасаж, нийтийн тээврийн үйлчилгээний хэсэгт шилжүүлсэн,
5. Нохой устгалын хэсгийг ногоон байгууламжийн хэсэгт, хог түрж булах хэсгийг хог хаягдлын хэсэгт нийлүүлсэн.

Компанийн хэсгүүдийн гүйцэтгэж буй ажил, чиг үүргийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №7

д/д	Бүтэц	Орон, тоо	Гүйцэтгэж буй ажил, чиг үүрэг
		2023 он	
1	Захиргаа, аж ахуй	7	Удирдлага, санхүү, зохион байгуулалт
2	Хог хаягдал	35	Мөрөн сумын нийт хог хаягдал цуглуулах, тээвэрлэх /жилд дунджаар 30 мянган тонн/
		2	Хог хаягдлыг хэмжих
		2	Хог хаягдал булшлах
3	Зам талбайн цэвэрлэгээ, арчилгаа	11	Мөрөн сумын нийтийн эзэмшлийн 369,545 м.кв талбайн цэвэрлэгээ
4	Ногоон байгууламж, төлөвлөлт, арчилгаа	7	Нийтийн эзэмшлийн 94,304 м.кв талбайн ногоон байгууламжийн арчилгаа үйлчилгээ,
		4	Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн засвар үйлчилгээ
			Чулууны үйлдвэрийн үйл ажиллагаа
5	Нийтийн тээвэр, үйлчилгээний хэсэг	1	Чулууны үйлдвэрийн барилгын сахиул
		2	Компанийн техник, хэрэгслийн засвар үйлчилгээ,
		1	Нохой устгал /жилд
6	Гэрэлтүүлэг	8	Нийтийн тээвэр
		2	Автограшийн сахиул
		3	Мөрөн сумын 7 гэрлэн дохио, 4,564 гэрэлтүүлгийн засвар үйлчилгээ
Нийт		85	

Хэрэгжүүлж буй чиг үүрэг болон ажиллах хүчний нөөц, бүтэц, орон тооны байдлаас үзэхэд компани бүтэц, зохион байгуулалтыг ажлын гүйцэтгэл, цалинг нэмэгдүүлэхэд чиглүүлж хэрэгжүүлсэн боловч зарим талаар ажилтны эрх ашгийг хохироох, үр ашиггүй тэтгэмж олгох, шаардлагатай орон тоог нэмэгдүүлээгүй байх, ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар арга хэмжээ аваагүй байх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгосон байна. Тухайлбал:

- Компанийн бүтэц, орон тоог 2021-2023 онд 4 удаа өөрчилсөн, ажиллах хүчний тогтворгүй байдал үүсгэсэн.
- Нягтлан бодогч 2019-2023 оны хооронд 4 удаа солигдсон.

- 2022 оны бүтэц орон тооны өөрчлөлтөөр 3 ачигч, 1 ковшийн жолоочийн орон тоог хасаж 2023 оны өөрчлөлтөөр тус орон тоонуудыг буцаан нэмсэн, /ажилчдын тэтгэмжтэй холбоотой зөрчлийг бүлэг Б.2.2-оос үзнэ үү/
- Компанийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй нийт техник, хэрэгсэл байнгын эвдрэлтэй, засварчны орон тоо, хүрэлцээ хангалтгүй байхад засварчны орон тоог нэмэгдүүлээгүй байна. Тухайлбал: Тогтмол ашиглагдаж буй 17 машин, механизм дунд инженерийг хасвал 1 засварчин ажиллаж байгаа нь байнгын үйл ажиллагааг хангах боломжгүй үзүүлэлт юм.

Дээрх байдлаас үзэхэд компанийн бүтэц, орон тооны удирдлага, зохион байгуулалт хангалтгүй түвшинд байна.

А.2.2 Компани нь энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагааг хууль журамд заасан зөвшөөрөлгүй гүйцэтгэж байна.

Хог хаягдлын тухай хууль болон БОАЖС-ын 2018 оны А/443 дугаар тушаалаар баталсан “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-д “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв”ХХК нийцэж буй эсэхийг хянахад дараах шаардлагуудыг хангахгүй байна. Үүнд:

1. Хог хаягдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1³, 16 дугаар зүйлийн 16.1⁴-т тус тус заасны дагуу компани нь БОАЖЯ-нд бүртгүүлээгүй, дугаар аваагүй байна.

2. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.22⁵-т заасны дагуу хог хаягдал булшлах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг даргаас аваагүй байна.

Зөрчилд хог хаягдлын үйл ажиллагааг хууль ёсны зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

А.2.3 Компанийн үндсэн чиг үүрэгт хамааралгүй, ашиглалтгүй эд хөрөнгийн элэгдэлд жил бүр 41.6 сая төгрөгийн алдагдал хүлээж байна.

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв”ХХК-д 2019-2022 онд улс, аймаг, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,402.3 сая төгрөгийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна. Хөрөнгө оруулалтын хэмжээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №8

Эх үүсвэр	Хэрэгжсэн он	Төсөвт өртөг /сая.төгрөг/	Хийгдсэн хөрөнгө оруулалт /товч/
Улсын төсвийн	2019-2020	983.3	Автограж-1ш, хог хаягдал тээвэрлэх автомашин – 6 ш, ковш -1 ш, хог хаягдал ангилах ялгах хашаа, хог хаягдал тээвэрлэх чингэлэг болон бусад
Аймгийн төсвийн	2020	305.5	Нийтийн тээврийн автобус – 5ш, хог хаягдал тээвэрлэх автомашин – 1ш
Сумын төсвийн	2022	1,113.5	Хог хаягдал тээвэрлэх автомашин – 2ш, Гэрэлтүүлгийн крантай автомашин – 1ш, Зам талбай цэвэрлэх автомашин – 1ш, Хог хаягдал тээвэрлэх чингэлэг болон бусад
Нийт		2,402.3	

³ Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь энэ хуулийн 8.1.9.б-д заасны дагуу бүртгүүлж, дугаар авсан байна.

⁴ Энгийн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 8.1.9.б-д заасны дагуу бүртгүүлж, дугаар авсан байна.

⁵ “Байгаль орчны чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно: энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх - Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга”

Дээрх хөрөнгө оруулалтууд нь “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв”ХХК-ийн одоогийн үйл ажиллагааг хангаж байгаа бөгөөд өмнө нь ашиглагдаж байсан техник хэрэгслүүд бүрэн ашиглалтын шаардлага хангахгүй болсон байна.

Хөрөнгийн ашиглалтын байдалд хяналт хийхэд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг бүрэн хүчин чадлаар ашиглаагүй, бүртгэлд тусгагдсан үл хөдлөх эд хөрөнгүүдийн гэрчилгээг компанийн нэр дээр гаргуулаагүй, ашиглалтгүй хөрөнгийн элэгдлийг хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгасан, зарим үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд техникийн хүчин чадал хүрэлцэхгүй байгаа зэрэг асуудлууд байна.

Тухайлбал:

- Хоймор нутгийн чулуу ХХК-аас шилжиж ирсэн үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмж ямар ч ашиглалтгүй байгаагаас компани нь үйлдвэрийн барилга, техник тоног төхөөрөмжийн элэгдэлд жилд 31.8 сая төгрөгийн/хүснэгт №9/ зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэж байна. Өмнө нь үр ашиггүй болох нь тогтоогдсон “Хоймор нутгийн чулуу”ХХК-ийн үйлдвэрийн барилга, эд хөрөнгийг тус компанид нийлүүлсэн нь компанийн үр ашгийг бууруулж, алдагдалтай ажиллах нөхцөл байдлыг бий болгоод байна.

д/д	Хөрөнгийн нэр	Хүснэгт № 9
		Жилийн Элэгдэл /сая.төг/
1	Гاغнуурын аппарат наадаг	0.5
2	Гар цахилгаан таслагч хөрөө	0.2
3	Компресср	0.3
4	Молдок гар	0.1
5	Ховил татагч хөрөө	2.0
6	Чулуу зүсэгч суурин хөрөө	5.0
7	Чулуу заслагч хөрөө	2.5
8	Чулуу шоологч таслагч машин	1.5
9	Самбар	0.6
10	Үйлдвэрийн барилга	4.6
11	Уурын зуухны барилга	0.1
12	Өргөгчтэй машин поо	2.2
13	Хово машин /78-92ХӨҮ/	2.9
14	Чиргүүл хово	0.7
15	Кран /96-90 ХӨҮ/	4.0
16	Үйлдвэрийн барилга	4.6
17	Уурын зуухны барилга	0.1
Нийт		31.8

Цаашид хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахад мэргэжлийн боловсон хүчин шаардлагатай, цалин, материал, шатахуун зэрэг зардал гарч компанийн алдагдлыг нэмэгдүүлэх тул чулууны үйлдвэрийн хөрөнгийг худалдан борлуулж компанийн алдагдлыг бууруулах зүйтэй байна.

- Ашиглалтын хугацаа дуусаагүй 1 автомашиныг задалж бусад машиныг сэлбэн ашиглалтгүй болгосноос тухайн автомашины элэгдэлд

9.8 сая төгрөгийн зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэж байна,

- Компанийн эзэмшилд байгаа 2 автограж, 1 үйлдвэрийн барилгын үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг компанийн нэр дээр гаргуулж баталгаажуулаагүй байна.
- Хог цуглуулах, тээвэрлэх машин механизмын хүрэлцээнээс шалтгаалан сумын Засаг даргын баталсан хуваарийн дагуу Мөрөн сумын гэр хорооллын хог хаягдлыг нэг цэгээс 30-45 хоногт 1 удаа тээвэрлэж байгаа нь цаашид хог тээврийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.
- Мөрөн сумын төвлөрсөн хогийн цэгийн хог булшлах үйл ажиллагаанд одоогийн байдлаар дугуйт ковш ашиглаж байгаа ба хогийн цэгийг хумихад тооны хувьд хүрэлцээгүй, дугуй нь байнга хагарч үйл ажиллагааг доголдуулах, техникийн боломж нь ажлын шаардлагыг хангахгүй байх зэрэг нөхцөл үүсч байна.

Дээрх илэрсэн асуудлуудаас үзэхэд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар компанид нийлүүлсэн хөрөнгүүд нь компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтууд байсан боловч хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөх, шаардлага хангасан техник тоног төхөөрөмж авахад дараах зүйлсийг анхаарах шаардлагатай байна. Үүнд:

1. Сэлбэгийн олдоц, нийлүүлэлтийн шуурхай байдал – сэлбэг олдохгүй байсан учир нэг машиныг задалж бусад машиныг сэлбэсэн.
2. Ажиллах орчин нөхцөл – хог хаягдал түрж хумих дугуйт ковшийн дугуй байнга хагардаг.
3. Тоног, төхөөрөмжийн хүрэлцээ – Мөрөн сумын төвлөрсөн хогийн цэгийг хумих ажлыг ганц ковш машинаар гүйцэтгэж байна.

Мөрөн сумын Засаг даргаас бодлогын зорилтын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

1. “Хоггүй мөрөн” төслийн хүрээнд “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж 599.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийн хог хаягдал тээвэрлэх автомашин 2 ш, гэрэлтүүлгийн өргөгчтэй автомашин 1 ш, зам, талбай цэвэрлэх автомашин 1 ш, хог тээвэрлэх чингэлэг зэрэг тоног, төхөөрөмжөөр хангасан.
2. ХБНГУ-ын Барут хот, Мөрөн хот хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжсэн “Мөрөн хотын ахуйн хог хаягдлын тогтвортой менежментэд оруулах хувь нэмэр” төслийг 337.2 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн.

Төслийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна. Үүнд:

- Олон нийтэд чиглэсэн 30 сургагч багш бэлтгэх,
- Өсвөр үед чиглэсэн нөлөөллийн сургалтыг Дэлгэрмөрөн цогцолбор сургуульд туршилтаар хичээллүүлэх,
- Дахин ашиглах даавуун уутыг төрийн бус байгууллагаар хийлгэн иргэдэд тараах,
- Хог хаягдал ангилан ялгах хогийн сав хийж байршуулах, хог зөөвөрлөх сав хийж “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-д нийлүүлэх,
- Иргэд, олон нийтийг оролцуулсан “Мөрөндөө сайхан амьдаръя” зөвлөгөөнийг зохион байгуулах.

3. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Мөрөн хотын хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр цаашид авах арга хэмжээ бодлогын баримт бичиг” боловсруулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж гүйцэтгэгийг шалгаруулан боловсруулалтын шатанд явагдаж байна. Тус төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн нь хот тохижилтын талаар баримтлах бодлого, арга хэмжээг тодорхойлох нэн шаардлагатай хөрөнгө оруулалт болсон байна.

Аудитаар Мөрөн сумаас хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хянан үзэхэд дараах асуудлууд илэрч байна. Үүнд:

1. ХБНГУ-ын Барут хот, Мөрөн хот хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжсэн “Мөрөн хотын ахуйн хог хаягдлын тогтвортой менежментэд оруулах хувь нэмэр” төслийн сургалтыг/тогтмол бус/ хэрэгжүүлэхдээ өмнөх хамтын ажиллагааны хүрээнд бий болсон сургалт, мэдээллийн байрыг 10.7 сая төгрөгөөр түрээслэн ашигласан байна. Гэтэл сургалт мэдээлэл хийсэн байдлыг хянан үзэхэд дээрх түрээс төлсөн жилийн хугацаанд байрыг 1, 5, 11 дүгээр саруудад 3 удаагийн 8 өдрийн 64 цагийн сургалтыг богино хэмжээгээр зохион байгуулснаас өөр хэлбэрээр ашиглаагүй байна. Мөн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг тооцож ажиллаагүй, 30 сургагч багш нь хог хаягдлын чиглэлээр ямар ажил зохион байгуулж байгаа эсэх нь тодорхойгүй байна.
2. Тухайн сургалт мэдээлэл явуулж байгаа байр нь орон нутгийн өмчид бүртгэлтэй байхад түрээсийн гэрээг аймгийн Засаг даргатай бус Монгол Германы орон нутгийн хөгжлийн сантай байгуулсан нь хүчин төгөлдөр бус гэрээ болох боломжтой байна.
3. Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь орон нутгийн өмчид бүртгэлтэй байгаа хөрөнгийг “Монгол Германы орон нутгийн хөгжлийн сан” өмчлүүлж гэрчилгээ гаргасан байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4⁶, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2⁷, 28 дугаар зүйлийн 2⁸, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6.1⁹ дэх заалтуудад тус тус нийцэхгүй байна.

Дээрх хөрөнгө нь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд тусгагдсан, орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгийг бусдад эзэмшүүлсэн шийдвэр гаргасан асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

2. Мөрөн сумын ЗДТГ-ын Санхүү албаны дарга П.Одончимэг, эрүүл мэнд, нийтийн биеийн тамир бодлого, хариуцсан мэргэжилтэн Д.Оюунсайхан, байгаль орчны улсын байцаагч Соёлмаа, дотоод ажил, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн Б.Мөрөнчимэг, хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан О.Болдсайхан нарт төслийн зардалд тусгагдаагүй байхад 4.8 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 22 дугаар 22.1¹⁰ дэх заалтуудад нийцэхгүй байна.

А.2.4. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагаанд тавих дотоод болон ТУЗ-ийн хяналтын тогтолцоо бүрэн алдагдсан байна.

Компанийн гүйцэтгэх захирлаас аудитад хамрах онуудад байгууллагын дотоод хяналт, шалгалтын журмыг баталж, дотоод хяналтын нэгжийг байгуулан, хяналтын ажлын төлөвлөгөө гарган ажилласан байна. Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөг 2022 онд гаргаагүй боловч тодорхой хэмжээнд гүйцэтгэж ажилласан байна.

Дотоод хяналтын жилийн төлөвлөгөөг байгууллагын нийт үйл ажиллагааг хамарсан, тодорхой давтамжит хугацаанд хийж байхаар тооцон, 2021 онд 16 чиглэлээр 61 удаа, 2023 онд 17 чиглэлээр 166 удаа гүйцэтгэхээр заасан байна.

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв”ХХК-ийн дотоод хяналтын нэгж нь компанийн үйл ажиллагаанд дараах байдлаар хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

1. 2021 онд 61 удаагийн хяналт төлөвлөж 9 удаагийн,
2. 2022 онд хяналтын төлөвлөгөө гаргаагүй, 15 удаагийн,
3. 2023 оны хагас жилийн байдлаар 83 удаагийн хяналт төлөвлөж 10 удаагийн.

Хяналтыг ажилчдын цаг ашиглалт, шатахуун зарцуулалт, орлогын байдалд түлхүү хийсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарч чадаагүй байна. Дотоод хяналтын тайлан, дүгнэлттэй танилцахад дүгнэлт, зөвлөмж гаргаагүй байгаа нь дотоод хяналтыг үр дүн багатай хэрэгжүүлсэн болохыг харуулж байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 2.3-т "Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино." гэж заасантай нийцэхгүй байгаа тул цаашид дотоод хяналтыг сайжруулж ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

⁶ төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх.

⁷ Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөөт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.

⁸ Засгийн газраас тусгайлан журамласнаас бусад үл хөдлөх хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг төрийн өмчит хуулийн этгээд эдэлнэ.

⁹ Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг бүртгүүлэх тухай мэдүүлэгт дараах нотлох баримтыг хавсаргана: өмчлөх эрхийг нотолсон баримт бичиг

¹⁰ Албан тушаалтан өөрийн албан үүргийн дагуу авах цалин хөлснөөс гадна энэ хууль, бусад хуулиар хориглоогүй бусад ажил, алба, гэрээний урамшуулал, мөн хуулиар хориглоогүй аж ахуйн үйл ажиллагааны орлого олж болно.

Байгууллагын үйл ажиллагаанд ТУЗ-ийн Аудитын хорооноос хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4¹¹ дэх заалттай нийцэхгүй байх Аудитын хорооны хяналтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг ТУЗ-д хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дээрх байдлаас үзэхэд компанийн санхүүгийн болон үйл ажиллагаанд тавих дотоод болон гадаад /аудитын хороо/ хяналтын тогтолцоо бүрэн алдагдсан байна.

Компанийн бүтэц, орон тоог 2021-2023 оны хооронд 4 удаа өөрчилсөн, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан, хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн ашиглалт хангалтгүй, ашиглахгүй байгаа хөрөнгийн элэгдлийг зардалд шингээж, алдагдлыг тодорхой хэмжээнд нэмэгдүүлж байгаа нь үйл ажиллагааны үр дүнг бууруулж байна.

БҮЛЭГ Б:

МӨРӨН СУМЫН ХОТ ТОХИЖИЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗӨВХӨН ХОГ ХАЯГДЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГООР САНХҮҮЖҮҮЛЖ БАЙНА

Б.1. Мөрөн сумын хот тохижилт, үйлчилгээний бүх үйл ажиллагааг зөвхөн хог хаягдлын хураамжийн орлогоор санхүүжүүлж байна.

Б.1.1. Хог хаягдлын хураамжийн хэмжээг холбогдох аргачлалын дагуу тооцож, тогтоосон байна.

Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.4¹², 41 дүгээр зүйлийн 41.9¹³, 41 дүгээр зүйлийн 41.10¹⁴ дахь заалтууд болон бусад журмуудад зааснаар хог хаягдлын хураамж нь хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх, булшлах зардлыг санхүүжүүлэх хэмжээнд байж гүйцэтгэлээр олгогдох ёстой байна.

Мөрөн сумын хувьд 2017, 2022 онуудад хог хаягдлын хураамжийн хэмжээг 2 удаа шинэчлэн тогтоосон байна.

Сумын ИТХ-ын 2017 оны 09 дүгээр тогтоолоор хог хаягдлын хураамжийн хэмжээг айл, өрхөөс сар бүр 3,000 төгрөг, аж ахуй нэгж байгууллагаас үйл ажиллагаанаас хамааран 4,000 – 20,000 төгрөг байхаар баталсан байна. Тус хог хаягдлын хураамжийн хэмжээнээс шалтгаалан 2021-2022 онуудад хураамжийн орлогыг дунджаар 345.0 сая төгрөгөөр төлөвлөн үлдэгдэл санхүүжилтийг сумын орон нутгийн төсвөөс татаасаар санхүүжүүлж байсан байна. Гэвч тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дээрх төсөв хүрэлцэхгүй байснаас аймгийн төсвөөс дараах байдлаар нэмэлт санхүүжилт олгосон байна.

Тухайлбал:

- 2021 онд аймаг, сумын төсвийн тодотголоор 160.0 сая төгрөг,
- 2022 онд сумын төсвийн тодотголоор 25.2 сая төгрөг, аймгийн төсвийн тодотголоор 371.0 сая төгрөгийн санхүүжилтийг “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв”ХХК-ийн хэвийн үйл ажиллагааг хангахад нэмж олгосон байна.

¹¹ Энэ хуулийн 81.2-т заасан аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна:

¹² Хог хаягдлын талаар сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: хог хаягдлын үйлчилгээний хураамжаас төвлөрсөн орлогыг энэ хуулийн 41.9-д заасны дагуу зарцуулах

¹³ Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг дараахь үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна:

41.9.1.хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх;

41.9.2.хог хаягдлыг булшлах;

41.9.3.энэ хуулийн 41.7-д заасны дагуу хог хаягдлын үйлчилгээний хураамж төвлөрүүлсэн тохиолдолд үйлчилгээний шимтгэл төлөх.

¹⁴ Хог хаягдал цуглуулж тээвэрлэх үйл ажиллагааг энэ хуулийн 9.2.1-д заасан тарифыг үндэслэн цуглуулж, тээвэрлэсэн хог хаягдлын хэмжээгээр тооцож санхүүжүүлнэ

Дээрх байдлаас шалтгаалан Мөрөн сумын ИТХ-ын 2022 оны 14 дүгээр тогтоолоор айл, өрхийн сар бүрийн төлбөрийг 9,900 төгрөг, аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаанаас хамааран 10,000 – 40,000 төгрөг тогтоож хог хаягдлын хураамжийн хэмжээг шинэчлэн баталсан байна. Хог хаягдлын хураамжийн хэмжээг нэмэгдүүлснээр хог хаягдал тээвэрлэх, булшлах хэвийн үйл ажиллагааг хангах, төсвийн дарамтыг арилгахад чухал нөлөө үзүүлж байна. **Тухайлбал:**

- 2023 оны хагас жилийн байдлаар сумын хог хаягдлын хураамжийн орлогын 585.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа ба авлага нь 311.0 сая төгрөг байна. Энэ нь бүтэн жилийн байдлаар 1.6 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрөх боломжтойг харуулж байна.

Хог хаягдлын хураамжийн хэмжээ тогтоосон байдалд хяналт хийхэд Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192,А/243 дугаар тушаалаар баталсан “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлал” болон бусад аргачлалын дагуу холбогдох үзүүлэлтүүд, гарч байгаа зардал болон гарах зардлын хэмжээг нэг бүрчлэн тооцож, тогтоосон байна.

Б.1.2. Мөрөн сумын хот тохижилт, үйлчилгээний бүх үйл ажиллагааг зөвхөн хог хаягдлын хураамжийн орлогоор санхүүжүүлж байна

Мөрөн сумын Засаг дарга нь сумын хот тохижилт үйлчилгээг гэрээний үндсэн дээр “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв”ХХК-аар гүйцэтгүүлж байна. Аудитад хамрагдах онуудад Мөрөн сум нь Сангийн яамнаас тогтоосон төсвийн хуваарийн дагуу дараах байдлаар хот тохижилтын зардлыг хуваарилсан байна. Төсвийн хуваарийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №10/сая төгрөг/

д/д	Зориулалт	2021 он	2022 он	2023 он
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	71.9	59.4	80.7
2	Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх	598.6	554.0	457.7
3	Төвлөрсөн хогийн цэгүүдийн устгал, ариутгал, ашиглалтын үйлчилгээ /хог хаягдал түрж булах/	35.6	45.4	55.3
4	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ үйлчилгээ	97.8	114.8	132.6
5	Нийтийн эзэмшлийн байгууламжийн арчилгаа, тордолт	48.1	68.8	48.6
6	Хот доторх ногоон байгууламжийн үйлчилгээ	99.5	112.1	102.0
7	Хотын доторх золбин муур, нохой устгал	18.6	23.4	10
8	Нийтийн тээврийн алдагдалд олгох татаас	49.5	144.2	211.9
9	Гудамжны гэрэлтүүлэг	-	-	139.4
		1019.6	1,122.1	1,238.2

Хот тохижилтын гэрээний үнэ болох батлагдсан санхүүжилтийг ажлын гүйцэтгэл, мөрдөгдөж буй тарифт нийцэж буй эсэхийг хянахад дараах байдалтай байна. Үүнд:

1. Хог хаягдлын хураамжийн орлогоос 644.5 сая төгрөгийг 2023 онд ногоон байгууламж, нийтийн тээвэр, золбин нохой устгал, гудамжны гэрэлтүүлэг, нийтийн эзэмшлийн байгууламжийн арчилгаа, тордолт засварын үйлчилгээний зардалд төлөвлөж, төсөвт тусган зарцуулж байна. Энэ нь Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.4¹⁵, 41 дүгээр зүйлийн 41.9¹⁶ дэх заалтуудад нийцэхгүй байна.

2. Мөрөн сумаас хог хаягдал тээвэрлэх, нийтийн талбайн цэвэрлэгээ үйлчилгээнд зарцуулах санхүүжилтийг тарифын дагуу тооцож олгоогүй байна. **Тухайлбал:**

- Мөрөн сумаас тээвэрлэсэн хог хаягдлын санхүүжилтийг 2021, 2023 онуудад хүснэгтэд заасан хэмжээгээр дутуу тооцон олгосон байна. Хүснэгт №11 /сая.төг/

¹⁵Хог хаягдлын талаар сум, дүүргийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: хог хаягдлын үйлчилгээний хураамжаас төвлөрсөн орлогыг энэ хуулийн 41.9-д заасны дагуу зарцуулах;”;

¹⁶ Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг дараах үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна:

41.9.1.хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх;

41.9.2.хог хаягдлыг булшлах;

41.9.3.энэ хуулийн 41.7-д заасны дагуу хог хаягдлын үйлчилгээний хураамж төвлөрүүлсэн тохиолдолд үйлчилгээний шимтгэл төлөх.

Он	Тээвэрлэсэн хогны хэмжээ /тонн/	Тариф тонн тутамд	Олгох санхүүжилт	Олгосон санхүүжилт	Зөрүү
2021	36.6	20,237 ¹⁷	740.7	466.6	274.07
2022	20.5	20,237	414.9	554	(139.1)
2023 хагас жилд	21.0	57,434 ¹⁸	1,205.5	457.7	747.8

Энэ нь Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10¹⁹ дахь заалтад нийцэхгүй байна.

- Нийтийн эзэмшлийн зам, талбайн цэвэрлэгээний санхүүжилтийг хүснэгтэд заасан хэмжээгээр дутуу тооцон олгосон байна. Хүснэгт №12 /сая.төг/

Он	Цэвэрлэж буй талбайн хэмжээ /м.кв/	1 м.кв талбайг цэвэрлэх тариф	Олгох санхүүжилт	Олгож байгаа санхүүжилт	Зөрүү
2021	369,545	10,400	3,843.3	97.8	3,745.5
2022	369,545	10,400	3,843.3	114.8	3,728.5
2023	369,545	10,400	3,843.3	132.6	3,710.7

Энэ нь аймгийн ИТХ-ын 2020 оны 03 дугаар тогтоол, тогтоолоор баталсан "Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх тариф/1м.кв=10,400 төгрөг/"-т нийцэхгүй байна.

Мөн 1 м.кв талбайг цэвэрлэх тарифын хэмжээг аймгийн ИТХ-аас хэт өндрөөр тогтоосон байгаа нь Мөрөн сумын Засаг даргаас нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэх зардлын санхүүжилтийг тарифын дагуу тооцож, санхүүжүүлэх боломжгүй байдалд хүргэж байна. Иймд аймгийн ИТХ-д “Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх тариф”-ыг дахин тооцож, батлах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Санхүүгийн эх үүсвэрийг тогтоосон үнэ тарифын дагуу тооцож төлөвлөж, бүрэн санхүүжүүлэхгүй байгаа нь дараах сөрөг үр дагаврыг бий болгох магадлалтай байна.

Мөрөн сумын хувьд:

- Хот тохижилтын үйл ажиллагааны үр дүн хангалтгүй байх.
- Хот тохижилтын үйл ажиллагааг өрсөлдөөний зарчмаар, сонгон шалгаруулж шийдвэрлэх боломжгүй байх.

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв”ХХК-ийн хувьд:

- Компанийн үйл ажиллагаанд доголдол учруулах.
- Хот тохижилтын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө оруулалтыг компани өөрийн хөрөнгө оруулалтаар бий болгож чадахгүй байх.

Мөрөн сумын Засаг даргаас хот тохижилт үйлчилгээнд зарцуулах санхүүжилтийг хууль, тогтоомжид заасан тарифаар бүрэн тооцохгүй байгаагаас Мөрөн сумын хот тохижилт үйлчилгээний бүх үйл ажиллагааг зөвхөн хог хаягдлын хураамжийн орлогоор санхүүжүүлж байна

¹⁷ Мөрөн сумын ИТХ-ын 2020 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Энгийн хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх зардлын нэгж тариф”

¹⁸ Мөрөн сумын ИТХ-ын 2022 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Энгийн хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх зардлын нэгж тариф”

¹⁹ Хог хаягдал цуглуулж тээвэрлэх үйл ажиллагааг энэ хуулийн 9.2.1-д заасан тарифыг үндэслэн цуглуулж, тээвэрлэсэн хог хаягдлын хэмжээгээр тооцож санхүүжүүлнэ.

Б.2. Бизнес төлөвлөгөөнд тусгагдсан зардлаас 13.9 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, 20.1 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан, шатахууны зардлын нормыг алдаатай тооцсоноос 180.0 орчим сая төгрөгийг хэмнэх боломжийг алдсан байна.

Б.2.1. Компанийн зарим нэр төрлийн орлого 2021 онд 169.5 сая төгрөгөөр, 2022 онд 116.4 сая төгрөгөөр тус тус тасарсан үзүүлэлттэй байна.

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн бизнес төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн (цаашид ТУЗ гэх) 2021 оны 02 дугаар тогтоолоор, 2022 оны 10 дугаар тогтоолоор, 2023 оны 01 дугаар тогтоолоор тус тус баталсан байна.

Бизнес төлөвлөгөөнд 2021 оны нийт орлогыг 1,126.1 сая төгрөгөөр, 2022 оны нийт орлогыг 1,577.1 сая төгрөгөөр тооцож баталсан бол 2021 онд 1,195.4 сая төгрөг, 2022 онд 1,807.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Борлуулалтын орлогыг нэр төрлөөр ангилан, төлөвлөгөө гүйцэтгэлийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт №13 /мянган төгрөг/

№	Орлогын нэр төрөл	2021 он			2022 он		
		Төл	Гүйц	Зөрүү	Төл	Гүйц	Зөрүү
1	Орон нутгийн төсвийн санхүүжилт	831,580.6	859,580.6	188,000.0	996,873.8	1,122,090.2	25,216.4
2	Тодотголын орлого	-	160,000.0	-	270,643.4	271,277.0	100,633.6
3	Чингүнжавын талбайн болон бусад талбайн түрээсийн орлого	3,375.0	-	(3,375.0)	3,375.0	8,705.5	5,330.5
4	Автобусны орлого	32,108.0	10,290.5	(21,817.5)	11,402.0	19,492.2	8,090.2
5	Хаяг рекламн самбарын орлого	4,740.0	4,590.0	(150.0)	4,740.0	6,174.0	1,434.0
6	Машин механизм түрээсийн орлого	73,948.7	88,233.8	14,285.0	62,698.0	11,826.7	(50,871.3)
7	Ногоон байгууламжийн орлого	3,235.0	26,754.4	23,519.4	6,605.0	58,794.4	52,189.4
8	ОНХС санхүүжилт	-	-	-	135,503.0	135,503.0	-
9	Ус хүргэх үйлчилгээний орлого	2,900.0	4,664.0	1,764.0	6,000.0	3,375.0	(2,625.0)
10	Тоглоомын орлого	59,974.0	1,203.7	(58,770.3)	14,000.0	47,741.8	33,741.7
11	Чулууны үйлдвэрийн орлого	106,230.0	25,303.2	(80,926.8)	65,300.0	2,350.0	(62,950.0)
12	Нохой устгал	3,556.2	3,841.5	285.3			
13	Газар ашиглуулсны түрээс	4,500.0	-	(4,500.0)			
14	Бусад	-	10,905.8	10,905.8		27,862.6	27,862.6
15	Үнэ төлбөргүй бараа материалын орлого	-	-	-		92,070.0	92,070.0
Нийт дүн		1,126,149.6	1,195,367.5	62,219.9	1,577,140.2	1,807,262.5	230,122.2

2021 онд ковид-19 цар тахлын улмаас хүүхдийн тогтоом, нийтийн тээвэр гэх мэт нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулаагүйгээс 6 нэр төрлийн 169.5 сая төгрөгийн орлого тасарсан, 2022 онд 116.4 сая төгрөгийн орлого нэр төрлөөрөө тасарсан ч нийт орлого 14.6 хувиар давж биелсэн үзүүлэлттэй байна.

Аудитаар 2022 оныг сонгон 13 нэр төрлийн орлогыг нотлох баримттай тулган шалгахад дараах зөрчилтэй асуудлууд илэрлээ. Орлогын тулгалт хийж, нэгтгэсэн хүснэгтийг хавсралт № 1-ээс үзнэ үү.

- ❖ Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын нэр төрлийг 1.1 сая төгрөгөөр зөрүүлж бүртгэсэн, үүнээс шалтгаалан дараа жилийн орлогын төлөвлөгөөг бодит гүйцэтгэлээс зөрүүтэй төлөвлөсөн, бизнес төлөвлөгөөнд тусгасан 3 нэр төрлийн 116.4 сая төгрөгийн орлого тасарсан үзүүлэлттэй байна. Энэ нь СТОУС 1.27-29-д заасан үнэн зөв толилуулга, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 жинхэнэ хэрэгжилтийн байх, 5.1.4 үнэн зөв байх заалтуудтай тус тус нийцэхгүй байна. /Зөрчилд зөвлөмж хүргүүлсэн/
- ❖ Хүүхдийн парк болон автобусны орлогын гүйцэтгэлд тавих хяналт сул байна. /тасалбар таслахгүйгээр олж байгаа орлогод хяналт тавиагүй/
- ❖ Хог хаягдлын хураамжийн орлого төлөвлөлт болон гүйцэтгэлд компанийн зүгээс ямар ч оролцоогүй ажиллаж байна.
- ❖ Ус худалдан борлуулах зөвшөөрөлгүй гэсэн шалтгаанаар зарим ус хүргэлтийн үйл ажиллагааг зогсоосон байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагаанаас олсон орлогыг нэр төрлөөр зөрүүлэн бүртгэсэн, орлогод бүрэн хяналт тавьж чадаагүй, бизнес төлөвлөгөөнд тусгасан орлогыг бүрэн биелүүлээгүй, хог хаягдлын хураамжийн орлого бүрдүүлэлтэд тавих хяналт байхгүй зэргээс харахад компанийн орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй, төлөвлөсөн орлогыг бүрэн бүрдүүлээгүй, үнэн зөв тайлагнаж чадаагүй байна.

“Хөвсгөл эрчим хүч”ХХК-ийн гэрээний дагуу гүйцэтгэсэн орлого бүрдүүлэлтийн талаар:

Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн санхүүгийн эх үүсвэрийн нэг хэсэг бол орон нутгийн төсвийн санхүүжилт бөгөөд түүнийг бүрдүүлдэг хог хаягдлын хураамжийн орлогыг Мөрөн сумын засаг дарга, Хөвсгөл эрчим хүч ХХК-тай гэрээ /Цаашид хамтран ажиллах гэрээ гэх/ байгуулан орлого бүрдүүлэх ажлыг гүйцэтгүүлж байна.

2022 оны хог хаягдлын хураамжийн орлогыг нэг өрхөөс 3000 төгрөгөөр тооцож 10 дугаар сард 1,2,3,10 дугаар сарын хураамжийг, 11 дүгээр сард 4,5,6,11 дүгээр сарын хураамжийг, 12 дугаар сард 7,8,9,12 дугаар сарын хог хаягдлын хураамжийг хэрэглэгчдийн цахилгааны төлбөр дээр нэмж хураахаар гэрээлсэн байна. Харин Мөрөн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 14 дүгээр тогтоолоор хог хаягдлын хураамжийн хэмжээг шинэчлэн нэг өрхөөс 9900 төгрөг байхаар тогтоосон байна.

Хамтран ажиллах гэрээнд Хөвсгөл эрчим хүч ХХК хураасан орлогоос 10 хувийн урамшуулал авахаар тусгасан байна.

Хог хаягдал цуглуулж, тээвэрлэх, булшлах үйл ажиллагааны санхүүжилт хүрэлцээгүйгээс шалтгаалан хог хаягдлын хураамжийн хэмжээг өмнөх оноос 3 дахин нэмэгдүүлсэн боловч “Хөвсгөл Эрчим хүч” ХХК-ийн суутган тооцож байгаа урамшууллын хэмжээ 10 хувь хэвээрээ байгаа нь орон нутгийн хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөө биелэхгүй байх сөрөг нөлөөтэй байна. Мөн иргэдийн цахилгааны төлбөр дээр хог хаягдлын хураамжийг нэмж суутгаж байгаа ажил нь хэвээрээ байгаа боловч суутгаж буй урамшууллын хэмжээ нь өмнөх жилтэй харьцуулахад (3000:9900) гурав дахин нэмэгдсэн байна.

2023 оны хог хаягдлын хураамжийн орлогын байдлыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 14 /мянган төгрөг/

№	Сар	Эхний үлдэгдэл	Бичилт	Төвлөрсөн орлого	Шимтгэл	Шилжүүлэх дүн	Шилжүүлсэн дүн	Эцсийн үлдэгдэл			
								Өглөг	Авлага	Зөрүү	Цэгийн тоо
1	1-р сар	50,014	96,928	104,554	9,693	94,861	94,914	42,335	36,328	6,006	10562
2	2-р сар	42,335	98,310	74,406	9,831	64,575	40,100	90,713	60,233	30,481	10585
3	3-р сар	90,713	99,429	110,412	9,943	100,469	110,184	70,015	49,249	20,766	10689
1-р улирлын дүн		294,666	289,371	29,467	259,905	245,198	203,063	145,810	57,253		
4	4-р сар	70,015	100,092	102,230	10,009	92,221	100,180	59,918	47,111	12,806	10711
5	5-р сар	59,918	100,092	108,090	10,009	98,081	90,200	59,800	39,113	20,687	10759
6	6-р сар	59,800	100,825	85,626	10,082	75,544	70,712	79,831	78,885	945.7	10791
2-р улирлын дүн		301,008	295,947	30,101	265,846	261,092	199,549	165,109	34,439		
Нийт дүн		595,675	585,318	59,567	525,751	506,290	402,612	310,920	91,692		

Аудитаар 2023 оны 05 дугаар сарыг сонгон авч борлуулалтын орлогыг тулгаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илэрсэнгүй.

Аудитын уулзалтаар “Хөвсгөл Эрчим хүч”ХХК нь хог хаягдлын хураамжийг төвлөрүүлэхэд цахилгааны төлбөр өндөр гарсан мэт сэтгэгдлийг иргэдэд төрүүлдэг, үүнээс шалтгаалан иргэдийн дарамт борлуулалтын албаны ажилчдад ирдэг байна. Иймд хог хаягдлын хураамжийн урамшууллыг борлуулалтын албаны ажилчдын ажлын ачааллыг харгалзан үзэж, тодорхой нэмэгдэл олгоход зарцуулах боломжтой байна. Дээрх асуудлын нөхцөл байдлыг судлан үзэж, гаргах шийдэл, хүлээгдэж байгаа үр өгөөжийг харуулбал:

Одоогийн нөхцөл байдал	Шийдэл/Санал	Хүлээгдэж буй үр өгөөж
- Орлого, авлага, өр төлбөрийн хэмжээг хийсвэрээр өсгөж харагдуулах - Ажлын ачаалал нэмэгдсэн - Иргэдээс ирэх гомдол, дарамт нэмэгдсэн	- Гэрээний дагуу суутган тооцож байгаа 10 хувиас борлуулалтын ажилчдад урамшуулалт цалин олгох - МСЗДТГ гэрээнд заасан үүргээ биелүүлж хог хаягдлын хураамжийн талаар иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг тогтмол явуулах	- Ажилчдын сэтгэл ханамж нэмэгдэж, ажлаас халшрах байдал буурах - Иргэдийн гомдол санал буурах

Б.2.2. Бизнес төлөвлөгөөнд тусгагдсан зардлаас 13.9 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, 20.1 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан, шатахууны зардлын нормыг алдаатай тооцоноос 180.0 орчим сая төгрөгийг хэмнэх боломжийг алдсан байна.

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн нийт зардлыг 2021 онд 1,390.0 сая төгрөгөөр, 2022 онд 1,577.1 сая төгрөгөөр тооцож баталсан бол гүйцэтгэлээр 2021 онд 1,582.2 сая төгрөг буюу 13.8 хувиар хэтэрсэн, 2022 онд 2,041.4 сая төгрөг буюу 29.4 хувиар хэтрүүлэн зарцуулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №15 /сая төгрөг/					2022 оны зардал өмнөх оноос өссөн нь байгууллагын цалин хөлс нэмэгдсэн, шатахууны нормын
Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт	Хувь	
2021	1,390.1	1,582.2	192.1	113.8%	
2022	1,577.1	2,041.4	464.2	129.4%	

буруу тооцоолол болон бусад тооцоолоогүй зардлын өсөлттэй холбоотой байна.

Компани сүүлийн жилүүдэд их хэмжээний өр төлбөртэй, алдагдалтай ажиллаж байгаа нь дараах шалтгаантай байна:

- Компанийн урт болон богино хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулаагүй,
- Компанийн гүйцэтгэх захирал сүүлийн 5 жил тогтвортой ажиллаагүй, ойр ойрхон солигдсон

- Ерөнхий болон тооцооны нягтлан бодогчид сүүлийн 5 жилийн хугацаанд 4 удаа солигдсон
- Мэргэжлийн эдийн засагч байхгүй
- Дотоод хяналт хангалттай ажиллаагүй
- Чулууны үйлдвэрийг бүрэн хүчин чадлаар ажиллуулаагүй, тус үйлдвэрээс олох орлого тасарсан, орлогоос давсан зардал гарсан
- Төсвөөс олгох санхүүжилтийг төлөвлөлтөөс доогуур баталж олгодог

Компанийн удирдлага дээрх байдалд дүн шинжилгээ хийж зардал хэмнэх талаар арга хэмжээ авч эхэлж байгаагийн нэг нь 2023 оны 05 дугаар сараас эхлэн авто машинуудад шатахуун хэмжигч GPS суулгасан байна. Аудитаар дээрх арга хэмжээний үр дүнг гаргахын тулд 2023 оны шатахууны зарцуулалтад харьцуулалт хийхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №16 /мянган төгрөг/

Сарууд	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар
Дүн /мянган төгрөг/	31,903.2	37,388.1	49,610.2	38,019.4	41,697.6	19,131.9


Хүснэгтийн үзүүлэлтэд 6-р сард нийтийн тээвэр зогсолт хийгддэг учир нийтийн тээврийн шатахуун ороогүй дүнг харууллаа. Нийтийн тээвэрт сард дунджаар 8.0 сая төгрөгийн шатахуун /GPS суулгаагүй байх үеийн дүн/ зарцуулдаг байна. Хүснэгтээс харахад шатахууны зардал ойролцоогоор 50 орчим хувь буурсан сайн үр дүнтэй ажил болсон байгааг харж болохоор байна.

Харин өмнөх онуудад шатахууны зардлын нормыг алдаатай тооцсоноос 180.0 орчим сая төгрөгийг хэмнэх боломжийг алдсан байна.

Аудитаар 2022-2023 оны шатахууны зарцуулалтыг баримттай тулган шалгахад шинэчлэн тогтоосон нормоос хэтрүүлэн зарцуулсан зөрчил илэрсэн тул төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэж, холбогдох хэсэгт дэлгэрэнгүй оруулав.

Компанийн 2022 оны зардлын бүтцийг нийт зардалд эзэлж буй хувиар харуулбал:

Зураг №1



Зургаас харахад нийт зардлын дийлэнх буюу 36 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал, 4.9 хувийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 18.3 хувийг тээвэр шатахууны зардал, 18.6 хувийг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлууд эзэлж байна.

Аудитаар нийт зардалд өндөр хувь эзэлж буй цалин хөлс, нэмэгдэл, урамшил, тээвэр шатахуун, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлууд болон бусад зардлыг түүвэрлэн авч баримтын тулгалт хийхэд дараах зөрчилтэй асуудлууд илэрлээ. Үүнд:

- ❖ Анхан шатны баримтаар нотлогдоогүй 1.3 сая төгрөгийн томилолт, 2.4 сая төгрөгийн шатахууны зардлыг санхүүжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7²⁰ дахь заалтыг зөрчиж байна. /Зөрчилд төлбөрийн акт тогтоосон./

²⁰ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно

- ❖ Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн ажилчдад 6.1 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1²¹ дэх заалтад нийцэхгүй байна. /Зөрчилд төлбөрийн акт тогтоосон./
- ❖ Нэр бүхий 6 албан хаагчийг бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөхдөө мэдэгдэл хүргүүлээгүй, сонсох ажиллагаа зохион байгуулаагүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1²², 27 дугаар зүйлийн 27.2²³, 27.2.1²⁴ дахь заалтуудыг зөрчсөн байна. /Зөрчилд албан шаардлага хүргүүлсэн./
- ❖ 2023 оны бизнес төлөвлөгөөнд нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 14,000,000 (Арван дөрвөн сая) төгрөгөөр төлөвлөсөн болов эхний хагас жилийн байдлаар 34,494,000 (Гучин дөрвөн сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянган) төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 20,494,000 (Хорин сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянган) төгрөгийн хэтрэлттэй байна. Энэ нь “Мөрөн хот тохижилт, үйлчилгээний төв” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор баталсан бизнес төлөвлөгөөний нэг удаагийн тэтгэмж урамшуулал зардлын хэмжээг зөрчсөн байна. /Зөрчилд албан шаардлага хүргүүлсэн./
- ❖ Бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй, анхан шатны баримт хангалтгүй 2022 онд-1.9 сая төгрөг, 2023 онд- 3.5 сая төгрөгийн нэмэгдэл цалин хөлс тус тус олгосон байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.6²⁵, 81.6.2²⁶ дахь заалтад нийцээгүй, Хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйлийн 5.4 дэх заалтыг зөрчсөн байна. /Зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн./
- ❖ Компанийн үйл ажиллагааг хувийн тээврийн хэрэгслээр гүйцэтгэдэг захиргаа, аж ахуйн ажилчидад тээвэр шатахууны зардлыг тогтоосон нормоос 4.4 сая төгрөгөөр хэтрүүлэн олгосон байна. Энэ нь “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны А/01, 2023 оны А/02 дугаар тушаалаар тус тус баталсан бензин шатахууны норм батлах тухай тушаалын хавсралтаар баталсан хэмжээг зөрчсөн байна. /Зөрчилд төлбөрийн акт тогтоосон./

Компанийн цалин хөлсний хороо нь гүйцэтгэх удирдлагын цалин хөлсний дээд хязгаарыг тогтоогоогүй, энэ талаар санал боловсруулж ТУЗ-д танилцуулаагүй, цалин хөлсний зарцуулалтад хяналт тавиагүйгээс цалин хөлс, нэмэгдэл, урамшууллыг тооцож олгохдоо бизнес төлөвлөгөөнд батлагдсан дүнгээс хэтрүүлэн олгосон байна.

Аудитаар илэрсэн зөрчлөөс үзэхэд компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагын хяналт, хариуцлага султай байдгаас шалтгаалан батлагдсан санхүүжилтийг хэтрүүлж, зориулалт бусаар зарцуулсан байна.

Б.2.3. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тендерийн үнэлгээний шатны ажлын баримт үйлдээгүй, захиалагчид гэрээ байгуулах эрх олгох зөвлөмж хүргүүлээгүй, хуульд заасны дагуу архивын нэгж үүсгээгүй байна.

2023 оны худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн захирлын 2023 оны А/14, А/16 дугаар тушаалуудаар тус бүр 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

²¹ Энэ хуулийн 65.4.2, 80.1.1, 80.1.2, 80.1.3-т заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан ажилтанд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран ажил олгогч дараах хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно:

²² Захиргааны акт, захиргааны гэрээг батлан гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгоно,

²³ Сонсох ажиллагааны талаарх мэдэгдлийг эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдэд дараах байдлаар хүргүүлнэ:

²⁴ хорь буюу түүнээс доош тооны этгээдийг сонсохоор бол мэдэгдлийг этгээд тус бүрд шууд хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд утас, факс, шуудан, цахим болон бусад хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд ийнхүү мэдэгдсэнээ баримтжуулах;

²⁵ Энэ хуулийн 81.2-т заасан цалин, урамшууллын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна

²⁶ төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;

Тээвэр шатахуун болон сэлбэг хэрэгсэл нийлүүлэх гүйцэтгэгч сонгох сонгон шалгаруулалтыг дараах төсөвт өртөгт багтаан нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан байна.

Хүснэгт №17 /сая төгрөг/

№	Багц	Төсөвт өртөг	Тендерт оролцогчийн нэр	Тендерт шалгарсан, шалгараагүй үндэслэл
1	Тээвэр шатахуун	533.1	“Шунхлай” ХХК	<i>Шалгараагүй:</i> Санал болгосон үнэ: 498.7 сая төгрөг
			“Нэмэн” ХХК	<i>Шалгараагүй:</i> Санал болгосон үнэ: 471.9 сая төгрөг
			“Сод Монгол групп” ХХК	<i>Шалгарсан:</i> Санал болгосон үнэ: 492.1 сая төгрөг
2	Сэлбэг хэрэгсэл	120.6	Нэг ч оролцогч оролцоогүй	
Нийт төсөвт өртөг		553.7		

Тээвэр шатахуун, тосолгооны материал нийлүүлэхээр 3 оролцогч тендер ирүүлснээс “Нэмэн” ХХК нь тендерийн баталгаа ирүүлээгүй, татварын өртэй байсан учраас хянан үзэх шатанд хасагдаж, Хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр “Сод Монгол Групп” ХХК шалгарсан байна.

Сэлбэг хэрэгсэл нийлүүлэх гүйцэтгэгч сонгох сонгон шалгаруулалтыг 2 удаа цахимаар зарласан боловч нэг ч оролцогч тендер ирүүлээгүй тул Улаанбаатар хотын “Аж-Эрдэнэ” ХХК, Хөвсгөл аймгийн БУМННЗ компаниудтай шууд гэрээ байгуулан худалдан авалтыг хийсэн байна.

Гэвч дээрх сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа үнэлгээний хороо нь ирүүлсэн тендерийг үнэлсэн талаар баримт бичиг үйлдээгүй, захиалагчид гэрээ байгуулах эрх олгох талаар зөвлөмж өгөөгүй, тендерийн баримт бичгийг хуулийн дагуу архивын нэгж болгон хадгалаагүй бөгөөд Tender.gov.mn цахим системд тендерийн эцсийн үр дүнг бүрэн оруулаагүй байна. Мөн 2022 оны худалдан авах ажиллагааны баримт материалыг шаардсан хугацаанд ирүүлээгүй, шалтгааныг тодруулахад баримтыг олохгүй байна гэсэн тайлбар ирүүлсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дор дурдсан чиг үүрэгтэй байна: 47.2.1²⁷, 47.2.2²⁸, 49 дүгээр зүйлийн 49.1²⁹ дэх заалтуудад тус тус нийцэхгүй байна. /Зөрчилд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн/

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа сонгон шалгаруулалтын журмыг баримталсан боловч, үнэлэх шатны баримтыг үйлдээгүй, захиалагчид гэрээ байгуулах эрх олгох зөвлөмж хүргүүлээгүй, цахим системд үр дүнг бүрэн оруулаагүй, архивын нэгж бүрдүүлээгүй нь үнэлгээний хорооны гишүүдийн ажлын хариуцлагагүй байдлаас шалтгаалсан байна.

²⁷ Техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх

²⁸ Тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх. Уг шийдвэрийг энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан үндэслэлгүйгээр өөрчлөхийг хориглоно

²⁹ Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална

Б.2.4. Авлага, өр төлбөрийг барагдуулах талаар нэг удаагийн арга хэмжээ авсан ч, цаашид авлага, өр төлбөргүй ажиллах талаар бодитой ажил төлөвлөөгүй байна.

Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-нь 2021 онд 36.1 сая төгрөгийн авлагатай, 161.6 сая төгрөгийн өглөгтэй, 2022 онд 18.8 сая төгрөгийн авлагатай, 82.6 сая төгрөгийн өглөгтэй ажилласан байна.

2021, 2022 оны санхүүгийн байдлын тайлангаас дансны авлага, БХӨТ дансыг сонгон доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт №18 /сая төгрөг/

Код	Үзүүлэлт	2021 он	2022 он	2023 оны хагас жил	2021-2022 Өөрчлөлт	Хувь
2	Дансны авлага	36.1	18.4	18.4	(17.7)	(49.0)
8	Нийт авлагын дүн	36.1	18.4	18.4	(17.7)	(49.0)
11	Дансны өглөг	4.9	7.3	54.6	2.4	48.8
12	Цалингийн өглөг	0.4	0.8	0.8	0.3	67.5
13	Татварын өр	33.3	71.3	77.2	38.1	114.3
14	НДШ-н өглөг	123.0	3.2	(0.9)	(119.8)	(97.4)
	Бусад БХӨТ	-	-	1.1	-	
15	Богино хугацаат өр төлбөрийн дүн	161.6	82.6	132.7	(79.0)	(48.9)

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн 2022 оны санхүүгийн байдлын тайлангаарх дансны авлага өмнөх оноос 17.7 сая төгрөгөөр буюу 49 хувиар буурсан үзүүлэлттэй, мөн богино хугацаат өр төлбөрийн дүн өмнөх оноос 79.0 сая төгрөгөөр буюу 48.9 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь НДШ-ийн өрийг барагдуулах арга хэмжээг авч ажилласантай холбоотой байна.

Тус компани 2021 онд Галт сумын хог хаягдлыг хумих ажлыг гэрээгээр гүйцэтгэсэн байна. Тус ажлын гэрээг байгуулахдаа хийх ажлыг биеэр очиж харалгүй гэрээ байгуулсан бөгөөд ажлаа хийхээр очиход гэрээнд зааснаас их талбайн хог түрэх шаардлага тулгарсан байна. Энэ талаар сумын удирдлагуудтай амаар тохиролцож, гэрээний үнэд тохируулан ажлаа гүйцэтгэсэн ч ажлаа дутуу хийсэн гэсэн шалтгаанаар санхүүжилтийг хасаж олгосон бөгөөд үлдэгдэл санхүүжилтийг авлагаар бүртгэсэн байна.

2021 онд нийт өр төлбөрийн 76 хувийг НДШ-ийн өглөг эзэлж байсан бол 2022 онд нийт өр төлбөрийн 86.3 хувийг татварын өр эзэлж байна.

Компанийн одоогийн гүйцэтгэх захирал 2022 оны 07 дугаар сард ажлаа авахад 161.6 сая төгрөгийн богино хугацаат өртэй, үүнээс нийгмийн даатгалын шимтгэлийн 122.9 сая төгрөгийн өртэй, санхүүгийн хувьд маш хүнд нөхцөл байдалтай байжээ. Өр төлбөр үүссэн гол шалтгаан нь орон нутгаас олгох санхүүжилтийг төсвийн төслөөс 50 хувь бууруулж баталдаг бөгөөд 2021 онд ковид 19 цар тахлын улмаас компанийн үндсэн болон туслах үйл ажиллагаанаас олох орлого тасарсантай холбоотой гэж удирдлагын зүгээс тайлбарласан байна.


НДШ-ийн өртэй учраас компанийн ажилчдад цалингийн зээл болон бусад төрлийн зээлүүд олгогдохгүй, нийгмийн баталгаа алдагдах нөхцөл байдалд хүрсэн учир 2022 оны жилийн эцэст тус компанийн ажилчид аймгийн удирдлагуудаас нийгмийн даатгалын өр барагдуулах санхүүгийн дэмжлэг хүсэж, жагсаал цуглаан зохион байгуулсан байна. Үүний үр дүнд Засаг даргын нөөц сангаас 271.3 сая төгрөгийн дэмжлэг авч НДШ болон шатахууны өр төлбөрөө барагдуулсан байна.

Энэ нь нэг талаар компанийн 80 гаруй ажилчдын эрх ашгийн төлөөх зөв арга хэмжээ мэт боловч аймгийн төсвөөс төлөвлөгдөөгүй зардал гарсан сөрөг талтай алхам юм. 2021 онд үүссэн өр төлбөрийг **нэг удаагийн тодотголоор** шийдвэрлэсэн боловч компани цаашид хэрхэн орлогоо нэмэгдүүлэх, зардлаа бууруулах, өр төлбөргүй ажиллах талаар бодитой шийдэл гаргаагүй тул 2023 оны эхний хагас жилийн байдлаар БХӨТ-ийн хэмжээ дахин 2021 оны өрийн хэмжээтэй ойролцоо буюу 132.7 сая төгрөгт хүрсэн байгаа нь хүснэгтээс харагдаж байна.

Б.2.5-д үзүүлсэн санхүүгийн тайлангийн шинжилгээний дүнгээс харахад компани өөрт байгаа хөрөнгөө бүрэн ашиглаж чадвал борлуулалтын орлогыг 3 дахин нэмэгдүүлэх боломжтой тооцоолол гарсан.

Иймд компанийн удирдлага цаашид тогтвор суурьшилтай ажиллаж, хөрөнгийг зөв зохистой удирдаж, шатахууны зардлыг хэмнэх үр дүнтэй арга хэмжээ авсантай ижил бусад зардлыг хэмнэх талаар шинэ санал санаачилга гаргаж, цалин хөлсний шинэ систем нэвтрүүлж ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, дагаад орлого төвлөрүүлэлт нэмэгдэх, цаашид алдагдлаа нөхөх боломжтой байна.

Харин борлуулалтын орлогыг нэмэгдүүлсэн ч дөнгөж алдагдлаа нөхөөд ашиг хүртэх боломжгүй тул орон нутгийн төсвөөс олгож буй санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.



Б.2.5.Санхүүгийн тайланг 2022 онд 69.3 сая төгрөгөөр, 2023 оны хагас жилээр 5.5 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан байна.

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн Санхүүгийн алба нь ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч, нярав гэсэн 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр санхүүгийн үйл ажиллагааг эрхлэн явуулж байна. 2019-2023 оны хооронд нягтлан бодогч 5 удаа солигдсон байна.

Тус компанийн 2021 оны санхүүгийн тайланд “Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар”, 2022 оны санхүүгийн тайланд “Ихэрмөрөн - Аудит” ХХК тус тус аудит хийж өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн байна.

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК нь 2021 онд нягтлан бодох бүртгэлдээ Санхүүгийн тооцоолох төвийн Explorer программ ашиглаж байгаад аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу 2022 онд санхүүгийн программаа шинэчлэн Smartlogic компанийн Smart программыг 7.3 сая төгрөгөөр худалдан авч нягтлан бодох бүртгэлээ хөтөлж байна.

Аудитаар 2022-2023 оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг дахин тооцоолж, ерөнхий журнал болон баримтын тулгалтаар авлага, өр төлбөрийг бүрэн бүртгэсэн эсэхэд хяналт хэрэгжүүлэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ❖ 2022 оны санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардлыг 69.3 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна. Энэ нь СТОУС 1.27-29-д заасан үнэн зөв толилуулга, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 жинхэнэ хэрэгжилтийн байх, 5.1.4 үнэн зөв байх заалтуудтай нийцэхгүй байна.
- ❖ 2023 оны хагас жилийн тайланд 3.7 сая төгрөгийн авлага, 1.8 сая төгрөгийн хувь хүмүүст төлөх өглөгийг бүртгээгүй, харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг

шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалттай нийцэхгүй байна.

Бизнес төлөвлөгөөнд тусгагдсан зардлаас 13.9 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, бүтцийн өөрчлөлт хийж албан хаагчдыг ажлаас чөлөөлж 20.1 сая төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшуулалд зарцуулж үр ашиггүй зардал гаргасан, шатахууны зардлын нормыг алдаатай тооцсоноос 180.0 орчим сая төгрөгийг хэмнэх боломжийг алдсан, цалин хөлсний дээд хязгаарыг тогтоогоогүй, жил дараалан алдагдалтай ажиллаж байгаа зэргээс харахад санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод болон гадаад хяналт алдагдсан байгааг харуулж байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭ:

2022 оны санхүүгийн байдлын тайлан:

Хүснэгт №19 /сая төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4.7	48.1	43.3	916.8
2	Дансны авлага	36.1	18.4	(17.7)	(49.0)
3	Бусад авлага	-	0.4	0.4	100.0
4	Бараа материал	62.9	99.1	36.2	57.6
5	Урьдчилж төлсөн зардал	1.3	-	(1.3)	(100.0)
6	Эргэлтийн хөрөнгийн дүн	105.0	166.0	61.0	58.1
7	Үндсэн хөрөнгө	4,613.3	4,970.0	356.7	7.7
8	Биет бус хөрөнгө	0.9	8.8	7.9	876.4
9	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,614.2	4,978.8	364.6	7.9
10	Нийт хөрөнгийн дүн	4,719.2	5,144.8	425.6	9.0
11	Дансны өглөг	4.9	7.3	2.4	48.8
12	Цалингийн өглөг	0.4	0.8	0.3	67.5
13	Татварын өр	33.3	71.3	38.1	114.3
14	НДШ-н өглөг	123.0	3.2	(119.8)	(97.4)
15	Богино хугацаат өр төлбөрийн дүн	161.6	82.6	(79.0)	(48.9)
16	Эздийн өмч	6,772.5	6,772.5	-	0.0
17	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,492.5	2,492.5	-	0.0
18	Эздийн өмчийн бусад хэсэг	4,705.3	5,445.5	740.3	15.7
19	Хуримтлагдсан ашиг	(9,412.7)	(9,648.3)	(235.6)	2.5
20	Эздийн өмчийн дүн	4,557.6	5,062.2	504.6	11.1
21	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	4,719.2	5,144.8	425.6	9.0

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн 2022 оны санхүүгийн байдлын тайлангаарх дансны авлага өмнөх оноос 17.7 сая төгрөгөөр буюу 49 хувиар буурсан, бараа материал 36.2 сая төгрөг буюу 57.6 хувиар өссөн, нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 425.5 сая төгрөгөөр буюу 7.9 хувиар өссөн үзүүлэлттэй бол богино хугацаат өр төлбөрийн дүн өмнөх оноос 79.0 сая төгрөгөөр буюу 48.9 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь НДШ-ийн өрийг барагдуулах арга хэмжээг авч ажилласантай холбоотой байна.

ХӨРВӨХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА

ЭРГЭЛТИЙН ХАРЬЦАА

Компанийн эргэлтийн харьцааг оноор харьцуулан хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №20 /сая төгрөг/							Компанийн 2020-2021 онуудын эргэлтийн харьцаа 0.6 буюу эргэлтийн хөрөнгөөр богино хугацаат өр төлбөрөө барагдуулах боломжгүй, нэмэлт хөрөнгө шаардлагатай, санхүүгийн хувьд маш хүнд байдалтай байсан бол 2022 онд одоо байгаа эргэлтийн хөрөнгөөр 2 удаа өр төлөх чадвартай буюу нэмэлт хөрөнгө шаардлагагүй, санхүүгийн хувьд хэвийн түвшинд очсон байгааг харуулж байна.
Эргэлтийн харьцаа	2020		2021		2022		
	101.8	0.6	105.0	0.6	166.1	2.0	
	164.8		161.6		82.6		

ТҮРГЭН ХӨРВӨХ ХӨРӨНГИЙН ХАРЬЦАА

Компанийн түргэн хөрвөх хөрөнгийн харьцааг оноор харьцуулан хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	Хүснэгт №21			Хүснэгтээс үзэхэд компани мөнгөнд түргэн хөрвөх чадвартай хөрөнгөөр богино хугацаат өр төлөх чадвар өмнөх онуудаас нэмэгдсэн ч хэвийн түвшинд очоогүй байна. Энэ харьцаа
	2020 он	2021 он	2022 он	
	0.16	0.25	0.8	

1 байвал зохимжтой байх бөгөөд цаашид түргэн хөрвөх чадвартай хөрөнгөө нэмэгдүүлэх шаардлагатайг илтгэж байна.

АШИГТ АЖИЛЛАГААНЫ ШИНЖИЛГЭЭ

ХӨРӨНГИЙН ЭРГЭЦ

Хөрөнгийн эргэцийг оноор харьцуулан, хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хөрөнгийн эргэц	Хүснэгт №22			2020-2022 онуудад хөрөнгийн эргэц 1-ээс хэт доогуур буюу маш бага байгаа нь компанийн үндсэн хөрөнгийн ашиглалт муу, бараа материалын удирдлага хангалтгүй гэх мэт муу үзүүлэлтийг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл
	2020 он	2021 он	2022 он	
	0.02	0.24	0.36	

санхүүгийн тайланд тусгагдсан нийт хөрөнгө нь борлуулалтын орлогыг бий болгоход үр ашиггүй зарцуулагдаж байгааг харуулж байна.

Санхүүгийн тайлангийн шинжилгээгээр компани өөрт байгаа хөрөнгө бололцоогоо зохистой удирдаж, үр ашигтай ажиллуулж, одоо байгаа хөрөнгөө бүрэн хэмжээгээр ашиглаж чадвал борлуулалтын орлогоо 3 дахин нэмэгдүүлэх боломжтой бөгөөд, эргэлтийн хөрөнгөөр богино хугацаат өр төлбөрийг төлөх чадвартай, цаашид өрийн дарамтгүй ажиллах боломжтой гэсэн үр дүн харагдаж байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Компанийн засаглалыг хэрэгжүүлж байгаа Төлөөлөн удирдах зөвлөл нь стратеги төлөвлөгөөг батлаагүй, бизнес төлөвлөгөөг үйл ажиллагаанд нь нийцүүлэн боловсруулсан эсэхэд хяналт хэрэгжүүлээгүй, ТУЗ-ын дэргэд ажиллах хороод нь чиг үүргийн дагуу үр дүнтэй ажиллаагүй, гүйцэтгэх захирал болон компанийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй зэргээс харахад одоогийн засаглал нь компанийн менежментийг сайжруулж, оновчтой тогтолцоог бүрдүүлж чадаагүй байна.
2. Компанийн бүтцийг 2021-2023 оны хооронд 4 удаа шинэчлэн тогтоосон, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан, хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн ашиглалт хангалтгүй, ашиглахгүй байгаа хөрөнгийн элэгдлийг зардалд шингээж, алдагдлыг тодорхой хэмжээнд нэмэгдүүлж байгаа нь үйл ажиллагааны үр дүнг бууруулж байна.
3. Мөрөн сумын Засаг даргаас хот тохижилт үйлчилгээнд зарцуулах санхүүжилтийг хууль тогтоомжид заасан тарифаар бүрэн тооцож олгохгүй байгаагаас Мөрөн сумын хот тохижилт үйлчилгээний бүх үйл ажиллагааг зөвхөн хог хаягдлын хураамжийн орлогоор санхүүжүүлж байна.
4. Аймгийн ИТХ-ын 2020 оны 03 дугаар тогтоолоор “Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх тариф”-ыг хэт өндөр баталсан байгаа нь нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээний санхүүжилтийг тарифын дагуу тооцож олгох боломжгүй байдалд хүргэж байна.
5. Үндсэн болон туслах үйл ажиллагаанаас олсон орлогыг нэр төрлөөр зөрүүлэн бүртгэсэн, орлогод бүрэн хяналт тавьж чадаагүй, бизнес төлөвлөгөөнд тусгасан орлогыг бүрэн биелүүлээгүй, хог хаягдлын хураамжийн орлого бүрдүүлэлтэд тавих хяналт байхгүй зэргээс харахад компанийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж бүрдүүлээгүй байна.
6. Бизнес төлөвлөгөөнд тусгагдсан зардлаас 13.9 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, бүтцийн өөрчлөлт хийж албан хаагчдыг ажлаас чөлөөлж 20.1 сая төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшуулалд зарцуулж үр ашиггүй зардал гаргасан, шатахууны зардлын нормыг алдаатай тооцсноос 180.0 орчим сая төгрөгийг хэмнэх боломжийг алдсан, 116.4 сая төгрөгийн орлого тасарсан, цалин хөлсний дээд хязгаарыг тогтоогоогүй, жил дараалан алдагдалтай ажиллаж байгаа зэргээс харахад санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод болон гадаад хяналт алдагдсан байгааг харуулж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Г.Мөнгөнхуягт:

1. “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа хангалтгүй байгаад дүгнэлт хийж, хариуцлагын арга хэмжээг хэрэгжүүлэх
2. Компанийн удирдлага болон санхүүгийн үйл ажиллагаанд тавих байгууллагын дотоод болон ТУЗ-ийн хяналт алдагдсан тул засаглалын оновчтой хэлбэрт шилжүүлэх,
3. “Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх тариф”-ыг шинэчлэн тогтоох.

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Октябрьбаярт:

4. Стратегийн зорилтуудыг тодорхойлж, урт болон дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
5. Бизнес төлөвлөгөөг бодит тооцоо, судалгаанд үндэслэн боловсруулж, батлах
6. “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлд тусгагдсан ашиглалтгүй, үр өгөөжөө өгөхгүй байгаа хөрөнгийн жагсаалт гаргаж, шийдвэрлэх.
7. Компанийн дүрмийг үйл ажиллагааны чиглэл, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулах.
8. Компанийг цаашид үр ашигтай ажиллуулах талаар санал санаачилга гарган, ТУЗ-ын хороодын үйл ажиллагааг эрчимжүүлж, хяналт, хариуцлагыг сайжруулах.

Мөрөн сумын Засаг дарга Д.Идэр-Мөнхөд:

9. Хот, тохижилт үйлчилгээний санхүүжилтийг хууль тогтоомжид заасан тарифыг үндэслэн төлөвлөж, санхүүжүүлэх,
10. “Хөвсгөл Эрчим хүч” ХХК-тай байгуулсан гэрээнд заасан хог хаягдлын хураамж төвлөрүүлсний урамшууллын хувь хэмжээг ажлын ачаалалд тохируулан багасгах арга хэмжээ авах,
11. Хог хаягдлын хураамж нэмэгдсэн талаар иргэд, олон нийтэд мэдээлэл өгөх, соён гэгээрүүлэх ажлыг гэрээнд заасны дагуу гүйцэтгэх,
12. Мөрөн сумын онцлогт тохирсон Хог хаягдлын менежментийн дэд төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжүүлэх ажлыг 2023 онд багтаан зохион байгуулах,
13. Төрийн албан хаагчдаар үндсэн чиг үүрэгт нь хамаарахгүй ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй байх,

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Мөнх-Эрдэнэд:

14. Бизнес төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулж, мөрдөж ажиллах,
15. Бүтэц, орон тоог оновчтой, тогтвортой удирдаж, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх,
16. Илүү цагийг олгохдоо анхан шатны баримтын бүрдлийг хангаж, Гүйцэтгэх захиралд ТУЗ-ийн шийдвэрээр, бусад ажилчдад Гүйцэтгэх захирлын шийдвэрээр олгож байх,
17. Орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах талаар үр дүнтэй арга хэмжээ авч, орлого, зардлын бүртгэл тайлагналд хяналт тавих, зардлын төлөвлөгөөг хэтрүүлэн зарцуулахгүй байх, үр ашиггүй зардлыг хэмнэх, алдагдлыг бууруулах арга хэмжээ авч ажиллах
18. Авлага, өр төлбөрийг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч, цаашид авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах,
19. Байгаль, орчин аялал жуулчлалын яаманд Хог хаягдлын тухай хуульд заасны дагуу хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагааг бүртгүүлж, дугаар авах.
20. Аймгийн Засаг даргаас Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу хог хаягдал булшлах үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл авах.
21. Эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулж, ашиглалтгүй байгаа эд хөрөнгийг өмчийн эзэнд мэдэгдэж худалдан борлуулах арга хэмжээ авах.
22. Хог хаягдлын хураамжийн орлого төлөвлөлт, гүйцэтгэлд компанийн зүгээс оролцоотой ажиллах

Зөрчлийн жагсаалт:

/сая төгрөг/

№	Илэрсэн зөрчлийн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Утга	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа үр дүнгүй, хангалтгүй байна.						2	
2	Компанийн удирдлага болон санхүүгийн үйл ажиллагаанд тавих гадаад болон дотоод хяналт алдагдсан						3	
3	“Мөрөн хот тохижилт, үйлчилгээний төв” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь 2022, 2023 оны хурлаар дүрэмд заасан “стратегийн зорилтуудыг тодорхойлж, урт болон дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах” талаар хэлэлцээгүй бөгөөд гүйцэтгэх удирдлагаас стратеги төлөвлөгөөг боловсруулан хэлэлцүүлэхээр санал оруулаагүй байна.						1	
4	Компанийн бизнес төлөвлөгөөг бодит, тооцоо судалгаагүй, үндэслэлгүй баталсан						1	
5	Компанийн бизнес төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөсөн						1	
6	ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг байнгын, тогтмол, мэргэшсэн явуулах зорилгоор нэр дэвшүүлэх хороо, аудитын хороо, цалин урамшууллын зэрэг 3-н хороог байгуулсан боловч хороодын ажиллах журмыг баталж мөрдүүлээгүй байна.						1	
7	Компанийн дүрэмд заасан зарим чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй мөн дүрэмд заагаагүй зарим ажил үүргийг гүйцэтгэсэн						1	
8	Эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй, эрх бүхий албан тушаалтнаас тусгай зөвшөөрөл олгогдоогүй байхад зарим чиг үүргийг гүйцэтгэж байна. Үүнд: -Мөрөн сумын айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжийн хог хаягдал зайлуулах -“...авто замын арчилгаа, засварлалт...” -Байгалийн боржин чулуу, гантиг чулуу олборлох -Байгалийн чулуу боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх						1	
9	Нийтийн эзэмшлийн 1 м.кв зам талбайг цэвэрлэх тарифын хэмжээг (10,400 төгрөг) аймгийн ИТХ-аас хэт өндрөөр тогтоосон байгаа нь Мөрөн сумаас зардлын санхүүжилтийг тарифын дагуу тооцож, санхүүжүүлэх боломжгүй байдалд хүргэж байна.						1	
10	Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын нэр төрлийг 1.1 сая төгрөгөөр зөрүүлж бүртгэсэн, үүнээс шалтгаалан дараа жилийн орлогын төлөвлөгөөг бодит гүйцэтгэлээс зөрүүтэй төлөвлөсөн, бизнес төлөвлөгөөнд тусгасан 3 нэр төрлийн 116.4 сая төгрөгийн орлого тасарсан үзүүлэлттэй байна.	117.5					1	117.5
11	Анхан шатны баримтаар нотлогдоогүй 1.3 сая төгрөгийн томилолт, 2.4 сая төгрөгийн шатахууны зардлыг санхүүжүүлсэн байна.	3.7	1	3.7				
12	Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн ажилчдад 6.1 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна	6.1	1	6.1				

13	Нэр бүхий 6 албан хаагчийг бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөхдөө мэдэгдэл хүргүүлээгүй, сонсох ажиллагаа зохион байгуулаагүй байна.				1			
14	Цалин хөлсний хороо нь компанийн гүйцэтгэх удирдлагын цалингийн дээд хязгаарыг тогтоогоогүйгээс компанийн захирал өөрийн цалин урамшууллыг 2 удаа нэмэгдүүлэх саналыг өөрөө санаачилж, ТУЗ-аар батлуулан зарцуулсан байна.						1	
15	Компанийн үйл ажиллагааг хувийн тээврийн хэрэгслээр гүйцэтгэдэг захиргаа, аж ахуйн ажилчид тээвэр шатахууны зардлыг тогтоосон нормоос 4.0 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.	4.0	1	4.0				
16	2023 оны бизнес төлөвлөгөөнд нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 14,000,000 (Арван дөрвөн сая) төгрөгөөр төлөвлөсөн болов эхний хагас жилийн байдлаар 34,494,000 (Гучин дөрвөн сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянган) төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 20,494,000 (Хорин сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянган) төгрөгийн хэтрэлттэй байна.	20.5			1	20.5		
17	Бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй, анхан шатны баримт хангалтгүй 2022 онд-1.9 сая төгрөг, 2023 онд- 3.5 сая төгрөгийн нэмэгдэл цалин хөлс тус тус олгосон байна	5.4					1	5.4
18	Үнэлгээний хороо нь ирүүлсэн тендерийг үнэлсэн талаар баримт бичиг үйлдээгүй, захиалагчид гэрээ байгуулах эрх олгох талаар зөвлөмж өгөөгүй, тендерийн баримт бичгийг хуулийн дагуу архивын нэгж болгон хадгалаагүй бөгөөд Tender.gov.mn цахим системд тендерийн эцсийн үр дүнг бүрэн оруулаагүй байна.				1			
19	Мөрөн сумаас тээвэрлэх хог хаягдлын санхүүжилтийг тарифын дагуу тооцоогүй.							
20	Нийтийн эзэмшлийн зам, талбайн цэвэрлэгээний санхүүжилтийг тарифын дагуу тооцоогүй.							
21	Хог хаягдлын хураамжийн орлогоос ногоон байгууламж, нийтийн тээвэр, золбин нохой устгал, гудамжны гэрэлтүүлэг, нийтийн эзэмшлийн байгууламжийн арчилгаа, тордолт засварын үйлчилгээний санхүүжилтийг олгож байна.						2	
22	Хог хаягдлын хураамж нэмэгдсэн талаар иргэд, олон нийтэд мэдээлэл өгөх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулаагүй						1	
23	Хөрөнгийн ашиглалт хангалтгүй, ашиглалтгүй хөрөнгийн элэгдэлд 31.8 сая төгрөгийг хүлээн зөвшөөрч бүртгэж байна.	31.8					2	31.8
24	Компанийн бүтэц, орон тооны удирдлага, зохион байгуулалтыг хангалтгүй хэрэгжүүлсэн						1	
25	Дотоод хяналтыг хангалтгүй, үр дүнгүй хэрэгжүүлсэн							
26	"Мөрөн хотын ахуйн хог хаягдлын тогтвортой менежментэд оруулах хувь нэмэр" төслийн зардалд тусгагдаагүй байхад Мөрөн сумын ЗДТГ-ын 5 албан хаагчид 4.8 сая төгрөгийн урамшуулал олгосон.	4.8					1	4.8
Нийт		193.8	3	13.9	3	20.5	22	159.5

ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ӨГСӨН ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:


**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН АЖЛЫН АЛБА**
Нутгийн удирдлагын ордон, 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120.
Утас: (976) 7038 3330,
Цахим шуудан: aimginithural@khs.gov.mn
Цахим хуудас: Khovsgol Khural.mn

2023.08.14 № 04/258
танай 2023.08.14 -ны № 01/471 -т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ТАНАА**

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн
үйл ажиллагаа, санхүүжилт, үр дүн” гүйцэтгэлийн
аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.
Тайлангийн төслөөр аймгийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хуралд өгөх зөвлөмжийн төслийг хүлээн
зөвшөөрч байна.


БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ
ИРГЭНИЙ ОРОЛЦООНЫ
ХЭЛТСИЙН ДАРГА Р.МАШБАТ

Албан Бичиг А5docx
6712009107

Саналгүй


2. Мөрөн сумын Засаг дарга:


**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН
ЗАСАГ ДАРГА**
8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас: 7038 4316, Цахим шуудан: moronsum@khs.gov.mn,
Цахим хуудас: http://moron.khs.gov.mn

2023.08.15 № 01/638
танай 2023.08.14 -ны № 01/472 -т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний үйл
ажиллагаа, санхүүжилт, үр дүн” гүйцэтгэлийн
аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, холбогдох
саналаа хүргүүлэв.
Хавсралт 16 хуудастай.


ДАРГА Д.ИДЭРМӨНХ

6712009108

д/д	Мөрөн сумын Засаг даргын санал	Саналд өгсөн тайлбар
1	Сумын ТЕЗ-ийн төсвийн төслийг боловсруулж хүргүүлэхдээ ХТҮТөвийн төсвийг тарифаар тооцон хүргүүлдэг боловч тухайн жилийн төсвийн зарлагын хязгаарыг Сангийн яам болон аймгийн СТСХэлтэс баталж ирүүлэхдээ өмнөх оноос нэмэгдүүлдэггүй. Жил бүр сумын зарлагаас давсан орлогын зөрүүг аймгийн төсөвт төвлөрүүлэх байдлаар төсвийг баталдаг тул Хот тохижилтын зардлыг нэмэгдүүлэх боломжийг үлдээхгүй, олгохгүй байна.	Тайлангийн холбогдох хэсгийг дэмжиж байх тул хэвээр үлдээж, аймгийн ИТХ-д "Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх тариф" шинэчлэн батлах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.
2	Хог хаягдлын хураамжийн орлого нь 2021 онд 308,975.1 мянган төгрөг, 2022 онд 229,363.8 мянган төгрөг, 2023 оны хагас жилийн байдлаар 681,259.8 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Сумын ТЕЗ-ийн төсвийн төслийг боловсруулж хүргүүлэхдээ ХТҮТөвийн төсвийг тарифаар тооцон хүргүүлдэг боловч тухайн жилийн төсвийн зарлагын хязгаарыг Сангийн яам болон аймгийн СТСХэлтэс баталж ирүүлэхдээ өмнөх оноос нэмэгдүүлдэггүй, сумын зарлагаас давсан орлогын зөрүүг жил бүр аймгийн төсөвт төвлөрүүлэх байдлаар төсвийг баталдаг нь сумын Хот байгуулалтын асуудлууд болох Хог хаягдал, Гэрэлтүүлэг, Ногоон байгууламжийн асуудлыг шийдвэрлэх боломж олгохгүй байгаагаас ХТҮТ-ийг тарифаар санхүүжүүлэх боломжгүй нөхцлийг үүсгэж байгааг аймгийн Засаг дарга, аймгийн ИТХ-ын дарга нарт тайлбарлан мэдэгдэл хүргэж байсан болно. Мөрөн сумын төсвөөс аймгийн төсөвт 2022 онд 1,737,254.7 мянган төгрөг, 2023 онд 2,358,452.2 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлэхээр төсөвт тусгагдсан байна.	Тайлангийн холбогдох хэсгийг дэмжиж байх тул хэвээр үлдээв
3	2023.07.28-ны ИТХурлын хуралдаанаар батлагдсан "Сумын 2023 оны төсөвт тодотгол оруулах тухай тогтоол"-ын 05 дугаар хавсралтад Хот байгуулалтын төсвийг баталсан ба үүн дотор "Хог хаягдал орчны бохирдлыг цэвэрлэх, зайлуулах" - зардалд 1,070.0 сая төгрөгийн төсвийг тусгасан болно. /сумын тодотголын тогтоолыг хавсралтаар хүргүүлэв/	Нэмэгдүүлэн баталсан төсөв нь хагас жилийн гүйцэтгэлд хүрэхгүй байх тул тайлангийн холбогдох хэсгийг хэвээр үлдээв.
4	Аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд НАКОРА-АСО МН төсөл нэгтгэгдэж байсан ба төсөл хэрэгжиж дууссан тул Мөрөн Германы хөгжлийн сан нь тухайн Сургалтын төвийг эзэмшиж, ашиглах бүх үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа гэсэн тайлбарыг өгсөний дагуу Түрээсийн гэрээг тухайн сантай хийсэн болно. Германы санхүүжүүлэгч талаас төслийн Санхүүгийн төлөвлөгөөнд Мэдээллийн төвийн түрээс, ашиглалтын зардлыг тусгаж ирүүлсний дагуу шилжүүлсэн болно.	Тайлбар ирүүлсэн тул тайлангийн холбогдох хэсгийг хэвээр үлдээв.
5	Төслийн хүрээнд Политехникийн коллеж дээр хийгдэх ангилан ялгах савнуудын материалыг Сумын ТЕЗ-ийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулан батлуулж Цахим системд нээлттэй тендер зарлаж материалыг нийлүүлсэн ба тендерийн хэмнэлтээр Политехникийн коллеж Орон сууцны болон Гэр хорооллын ангилан ялгах савны нэг нэг ширхэг загвар савыг нэмж хийсэн болно. Үүнийг Германчуудыг Мөрөнд ирсэн байх үед ярилцаж шийдвэрлэсэн болно. Гэрээний Санхүүжилтийн төлөвлөгөөний дүнг хэтрүүлээгүй тул НББ-ийн анхан шатны баримтыг тайлбарлан танилцуулах хүсэлтэй байна.	Санал, нотлох баримтыг үндэслэн зөрчлөөс хассан
6	ЗДТГазрын ажилтнууд нь ДМЦСургууль дээр хэрэгжсэн сургуулийн төсөл, Политехникийн коллеж дээр хэрэгжсэн ангилан ялгах савыг гагнуурын мэргэжлийн оюутнуудаар хийлгэх төсөл, ЭКО мамы нэгдэл дээр хэрэгжсэн даавуун торны төсөл, сургагч багш нарын 1.2.3р сургалт, бусад нөлөөллийн ажлууд зэрэг Төслийн арга хэмжээ бүрийг хэрэгжүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, санхүү бүртгэл, тооцоог боловсруулан санхүүжүүлэгч талыг байнгын мэдээллээр ханган мэдээ, тайланг бэлтгэн хүргүүлэх зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэсэн. Мөрөн сумын иргэдэд нэн хэрэгцээтэй хөрөнгө оруулалт хийгдсэн энэхүү төслийг эхлэн бичиж	Саналыг хүлээн авч зөвлөмж болгов.

	Германы талд танилцуулахаас эхлэн хэрэгжүүлэх бүхий л үйл ажиллагаанд оролцсон ажилтнууд нь ажлын зав чөлөөгөөр, нэмэлт олон цагаар ажиллаж байсан тул Германы талын санхүүжүүлэгч, эрх бүхий ажилтнаас зөвшөөрөл авч урамшуулал олгосон тул Төлбөрийн акт тогтоохгүйгээр Зөвлөмж ирүүлэхийг хүсч байна. Цаашид ийм алдаа давтан гаргахгүй болно.	
7	Тогтвортой байдал, экологи, гар урлалын сургалтын төвийн цехийн барилгын төсөл нь "Мөрөн хотын ахуйн хог хаягдлын тогтвортой менежмент" төслөөс тусдаа төсөл ба энэхүү 2 төслийн санхүүжилт болон зарцуулалтыг Төрийн сангийн 100172255801-Мөрөн Герман хамтын ажиллагаа гэсэн нэг дансаар дамжуулан үйл ажиллагааг хэрэгжүүлсэн болно. П.Одончимэг-т "Тогтвортой байдал, экологи, гар урлалын сургалтын төвийн цехийн барилгын төсөл"-ийн бүх ү/ажиллагааны тайлан тооцооны урамшуулал олгохдоо Хог хаягдлын төслийн санхүүжилтээс олгоогүй болно. "Тогтвортой байдал, экологи, гар урлалын сургалтын төвийн цехийн барилгын төсөл"-ийн төсвийн 10%-ийг Орон нутгаас хариуцах гэрээтэй байсан тул ЗДТГазраас шилжүүлсэн Орон нутгийн 10%-ийн санхүүжилтээс олгосон болно. Германы талын санхүүжүүлэгч, эрх бүхий ажилтнаас зөвшөөрөл авч урамшуулал олгосон тул Төлбөрийн акт тогтоохгүйгээр Зөвлөмж ирүүлэхийг хүсч байна. Цаашид ийм алдаа давтан гаргахгүй болно.	Саналыг хүлээн авч зөвлөмж болгов.

3. “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв”ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл:



Саналгүй

“Мөрөн хотын тохижилт үйлчилгээний үйл ажиллагаа, санхүүжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг төлөөлөн удирдах зөвлөлийн даргад танилцууллаа.

Тус төсөлд өгөх санал байхгүй бөгөөд танай байгууллагаас гаргасан санал, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

ТУЗ-ИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА  УРАНГЭРЭЛ



4. “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв”ХХК:



Хариу хүргүүлэх тухай.

“Мөрөн хотын тохижилт үйлчилгээний үйл ажиллагаа, санхүүжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж дараах саналыг хавсралтаар хүргүүлж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
А. ЭРДЭНЭ

“МӨРӨН ХОТЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮЖИЛТ, ҮР ДҮН” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНД ШАЛГУУЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

1. Тус аудитаар А.1.6-д Хог хаягдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хянах тогтолцоо алдагдсан, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийг өмчлөлдөө авчирснаар хяналтын чиг үүрэг нь алдагдаж, Мөрөн сумын засаг дарга нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг зөвхөн гэрээ байгуулах хэмжээгээр хязгаарлуулан, хот тохижилтын үйл ажиллагаанд удирдлагын түвшинд чиглэл өгөх эрхгүй болсон байна гэжээ.
Хог хаягдлын тухай хуулиар иргэдээс авсан хог хаягдлын хураамжийн орлого сум, дүүргийн төсөвт төвлөрөх бөгөөд тухайн шатны Засаг дарга мэргэжлийн байгууллагаар гэрээгээр ажил гүйцэтгүүлэх эрхтэй. Иймээс манай байгууллага Мөрөн сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээний үндсэн дээр үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл, үр дүнд хяналт тавих, гэрээнд тусгагдсан асуудлаар шаардлага тавих, чиглэл өгөх эрх нь Мөрөн сумын Засаг даргад бий.
Мөн манай байгууллага аймгийн орон нутгийн өмчит компани болсон нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Хог хаягдлын тухай хуульд заасан хяналтын чиг үүргийг алдагдуулаагүй болно.
2. А.2.1-д Компанийн бүтэц, орон тоог 2021-2023 онд 4 удаа өөрчилсөн нь удирдлага зохион байгуулалт хангалтгүй байна гэж дүгнэжээ. Компанийн дүрэмд өөрчлөлт орсноор хэрэгжүүлэх үйл ажиллагаатай уялдуулан хүний нөөцөд тодорхой өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага үүссэн. Гүйцэтгэх захирал миний бие ажил хүлээж аваад тандалт шинжилгээ хийж үзэхэд манай байгууллага үндсэн 88, гэрээт 12, нийт 100 ажилтантай байсан бөгөөд сул зогсолт ихтэй, ажлын ачаалал тэнцвэргүйн дээр цалин бага, нийгмийн даатгалын өр төлбөрт орсон байсан. Иймд цалингийн зардлыг хэт өсгөхгүйгээр ажилчдын цалинг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын өр төлбөр үүсгэхгүй байх үүднээс бүтцийн өөрчлөлт хийж, цалингийн доод босгыг 480 мянган төгрөг байсныг 600 мянган төгрөг болгож нэмэгдүүлсэн.
Хэдийгээр бүтцийн өөрчлөлттэй холбоотой ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудад хуулийн дагуу 21,3 сая төгрөгийн тэтгэмж олгосон нь богино хугацаандаа үр ашгийг зардал боловч цалингийн зардлыг хэт өсгөхгүйгээр ажилтнуудын цалинг нэмэгдүүлсэн, нийгмийн даатгалын өндөр өр төлбөр үүсгэхгүй үйл ажиллагаа явуулж байгаа зэргээс харвал урт хугацаандаа үр ашигтай байна гэж үзэж байна.
3. Компанийн гүйцэтгэх удирдлага солигдсоноор өмнө нь ажиллаж байсан чулууны үйлвэрийн ажиллагсад өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөнөөр шинээр ажилтан авах, сургах хэрэгцээ шаардлага үүссэн. Иймд туршлага судлах, дадлагажуулах зорилгоор үйлдвэр, үйлчилгээний нэр бүхий 3 ажилтныг Улаанбаатар хотод томилолтоор ажиллуулж, ирж очих унааны шатахуун, буудал, хоол цайны зардалд 1,3 сая төгрөг зарцуулсан. Дээрх ажилтнууд чулуу зүсэх, өнгөлөх чадварт суралцсан бөгөөд явган замын хавтан, шатны марш, цонхны тавцан хийх чадвартай болсон. Иймд акт тавих шийдвэрээ эргэн харж өгнө үү.

Санал 1. Аймгийн ИТХ нь хог хаягдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянахдаа Мөрөн сумын Засаг дарга болон “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв”ХХК-ийн үйл ажиллагааг цуг харьцуулж дүгнэлт гаргах, Мөрөн сумын Засаг дарга хэрэгжилтийг хангахдаа гэрээгээр хязгаарлагдах, “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв”ХХК-ийн ашиг олох боломж хязгаарлагдмал, мөн Мөрөн сумын санхүүжилтээс шууд шалтгаалсан үйл ажиллагаа явуулж байгаа нь дээрх дүгнэлтэд хүргэсэн тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

Санал 2. 2 жилийн хугацаанд 4 удаа бүтэц, орон тооны өөрчлөлт хийсэн, цаашид дахиад өөрчлөлт хийх магадлалтай байгаа нь бүтэц, орон тооны өөрчлөлтийг урьдчилсан тооцоо, судалгаа муутай хийсэн байгааг харуулж байх тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

Санал 3. Анхан шатны нотлох баримт ирүүлээгүй тул санал тайлбарыг хүлээн авах боломжгүй байна.

oooOooo

2022 оны орлогын тулгалт								
№	Орлогын төрөл	Тайлагнасан			Түүвэрлэн тулгасан			
		Бизнес төлөвлөгөө	Тайлангаар	Зөрүү	Журналаар	Аудитаар	Орлогын зөрүү	Тайлбар
1	Орон нутгийн төсвийн санхүүжилт	996,873,800	1,022,090,200	25,216,400	1,022,090,200	1,022,090,200	-	
2	Тодотголын орлого	270,643,416	371,277,005	100,633,589	371,277,005	371,277,005	-	НДШ болон шатахууны өр төлсөн
3	Чингүнжавын талбай болон бусад талбайн түрээс	3,375,000	8,705,500	5,330,500	8,705,500	8,705,500	-	
4	Автобусны орлого	11,402,000	19,492,200	8,090,200	19,532,200	20,056,300	(564,100)	
5	Хаяг рекламн самбарын орлого	4,740,000	6,174,040	1,434,040	6,174,040	6,614,000	(439,960)	Нийт 48 самбараас 13 нь Алтандуулга компанийн өөрийн самбар, түүнээс самбар байрлуулсан газрын төлбөр авдаг. Үлдсэн 35-аас 10ш нь төрийн байгууллагынх төлбөр авдаггүй, 25-аас 19 самбар гэрээ байгуулсан байна. Үлдсэн 6 самбар гэрээ байгуулаагүй.
6	Машин механихзмийн түрээсийн орлого	62,698,022	11,826,700	(50,871,322)	11,826,700	11,826,700	-	Самбар байршуулахад шаардлагатай өргөгч машин 1 цагийн түрээс 80 мянган төгрөг байдаг. Ковш түрээслүүлдэг.
7	Ногоон байгууламжийн орлого	6,605,000	58,794,446	52,189,446	58,884,446	59,565,446	(771,000)	Хүүхдийн паркийн орлогод бүртгэсэн
8	ОНХС-ийн санхүүжилт	135,503,000	135,503,000	-	135,503,000	135,503,000	-	ОНХСангаас нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн цахилгааны зардал, гэрэлтүүлгийн ажилчдын цалин болон шатахууны зардал багтдаг. Нийт гарсан зардлыг түүвэрлэж илүү санхүүжилтийг харуулав
9	Ус хүргэх үйлчилгээний орлого	6,000,000	3,375,000	(2,625,000)	3,375,000	3,375,000	-	Захиалгаар ус хүргэж олдог орлого. 2023 онд ус хүргэлт бараг гарахгүй байгаа. Учир нь ус худалдан борлуулах зөвшөөрөлгүй
10	Тоглоомын орлого	14,000,000	47,741,766	33,741,766	47,741,766	47,060,766	681,000	Орлогын ангилал зөрүүлж бүртгэсэн, мөн баримтаар 27,932,000 төгрөгийн орлого олсон. Бусад баримт бүрдүүлээгүй.
11	Чулууны үйлдвэрийн орлого	65,300,000	2,350,000	(62,950,000)	2,350,000	2,350,000	-	
		1,577,140,238	1,687,329,857	110,189,619	1,687,459,857	1,688,423,917	(1,094,060)	
12	Бусад орлого	-	27,862,601	27,862,601	27,732,601	27,732,601	130,000	Ангилал зөрүүлж бүртгэсэн
13	Үнэ төлбөргүй нийлүүлсэн бараа материалын орлого	-	92,070,000	92,070,000	92,070,000	92,070,000	-	
	Нийт дүн	1,577,140,238	1,807,262,458	230,122,220	1,807,262,458	1,808,226,518	(964,060)	Орлого дутуу тайлагнасан

oooOooo

Төлбөрийн акт:



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 08 сарын 14 өдөр

№ 58/АБЭТОН/ХӨА-2023/47
ШТА - ГА

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэсэн “Мөрөн хотын тохижилт үйлчилгээний үйл ажиллагаа, санхүүжилт, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтаар нотлогдоогүй 1,292,500 (Нэг сая хоёр зуун ерэн хоёр мянга таван зуун) төгрөгийн томилолтын зардал, 2,426,626.4 (Хоёр сая дөрвөн зуун хорин зургаан мянга зургаан зуун хорин зургаан төгрөг дөрвөн мөнгө) төгрөгийн шатахууны зардлыг санхүүжүүлсэн байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан томилолт болон шатахууны зардал 3,719,126.4 (Гурван сая долоон зуун арван есөн мянга нэг зуун хорин зургаан төгрөг дөрвөн мөнгө) төгрөгийг Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн захирал С.Мөнх-Эрдэнэ, Нягтлан бодогч Г.Нандин-Эрдэнэ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

Г.ИЧИНХОРЛОО

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 08 сарын 14 өдөр

№ 59/А.22-70469/ХӨА-2023/47
УТА - 19

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Мөрөн хотын тохижилт үйлчилгээний үйл ажиллагаа, санхүүжилт, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тээвэр шатахууны зардлыг тогтоосон нормоос 4,022,563.3 (Дөрвөн сая хорин хоёр мянга таван зуун жаран гурван төгрөг гурван мөнгө) төгрөгөөр хэтрүүлэн олгосон байна.

Дээрх зөрчил нь Энэ нь “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны А/01 дугаар тушаал, 2023 оны А/02 дугаар тушаалаар тус тус баталсан бензин шатахууны норм батлах тухай тушаалын хавсралтад заасан хэмжээг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.6 “Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ** нь:

5. “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн шатахууны норм хэтрүүлэн зарцуулсан 4,022,563.3 (Дөрвөн сая хорин хоёр мянга таван зуун жаран гурван төгрөг гурван мөнгө) төгрөгийг Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;
6. Актын биелэлтийг 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт³ нотлох баримтын хамт ирүүлэхийг Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн захирал С.Мөнх-Эрдэнэ, Нягтлан бодогч Г.Нандин-Эрдэнэ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

Г.ИЧИНХОРЛОО

³ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 08 сарын 14 өдөр

№ 60/АЗЭТ-0469/ХӨА - 2023/47
107А - ГА

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэсэн “Мөрөн хотын тохижилт үйлчилгээний үйл ажиллагаа, санхүүжилт, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өөрийн хүсэлтээр болон сахилгын арга хэмжээ авах хэмжээний зөрчил гаргасан албан хаагчдыг ажлаас чөлөөлөхдөө 6,100,000 (Зургаан сая нэг зуун мянган) төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Дээрх зөрчил нь Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 “Энэ хуулийн 65.4.2, 80.1.1, 80.1.2, 80.1.3-т заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан ажилтанд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран ажил олгогч дараах хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно” гэсэн заалтын шалгуурт нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3-д “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

3. Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн нэг удаагийн тэтгэмж, урамшуулалд зарцуулсан 6,100,000 (Зургаан сая нэг зуун мянган) төгрөгийг Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;
4. Актын биелэлтийг 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт² нотлох баримтын хамт ирүүлэхийг Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн захирал С.Мөнх-Эрдэнэ, Нягтлан бодогч Г.Нандин-Эрдэнэ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

Г.ИЧИНХОРЛОО

² Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043

Албан шаардлага:



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 08 сарын 14 өдөр

№ 89/2220469/ХӨА-2023/47
ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Мөрөн хотын тохижилт үйлчилгээний үйл ажиллагаа, санхүүжилт, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэр бүхий 6 албан хаагчийг бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөхдөө Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу мэдэгдэл хүргүүлээгүй, сонсох ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т “Захиргааны акт, захиргааны гэрээг батлан гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгоно”, 27 дугаар зүйлийн 27.2-т “Сонсох ажиллагааны талаарх мэдэгдлийг эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдэд дараах байдлаар хүргүүлнэ”: 27.2.1-т “хорь буюу түүнээс доош тооны этгээдийг сонсохоор бол мэдэгдлийг этгээд тус бүрд шууд хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд утас, факс, шуудан, цахим болон бусад хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд ийнхүү мэдэгдсэнээ баримтжуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдийг ажлаас чөлөөлөхдөө урьдчилан мэдэгдээгүй, сонсох ажиллагаа зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 01 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлэх;
2. Цаашид дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхыг “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн захирал С.Мөнх-Эрдэнэ, Хүний нөөцийн мэргэжилтэн Т.Молор-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

ГИЧИНХОРЛОО

Монгол Улс, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байр 3 давхар 302 тоот



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 08 сарын 14 өдөр

№ 90/А22-Ж/189/ХӨА-2023/47
ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Мөрөн хотын тохижилт үйлчилгээний үйл ажиллагаа, санхүүжилт, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2023 оны бизнес төлөвлөгөөнд нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 14,000,000 (Арван дөрвөн сая) төгрөгөөр төлөвлөсөн болов эхний хагас жилийн байдлаар 34,494,000 (Гучин дөрвөн сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянган) төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 20,494,000 (Хорин сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянган) төгрөгийн хэтрэлттэй байна.

Энэ нь “Мөрөн хот тохижилт, үйлчилгээний төв” ХХК-ийн Төлөвлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор баталсан бизнес төлөвлөгөөний нэг удаагийн тэтгэмж урамшуулал зардлын хэмжээг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.5-д “Төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

3. Бизнес төлөвлөгөөгөөр батлагдсан зардлыг хэтрүүлэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 01 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлэх;
4. Цаашид дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхыг “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн захирал С.Мөнх-Эрдэнэ, нягтлан бодогч Г.Нандин-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР:



А.ЭРДЭНЭБААТАР

Г.ИЧИНХОРЛОО

Монгол Улс, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байр 3 давхар 302 тоот



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 08 сарын 14 өдөр

№ 91/АХЗТ0469/АОА-2023/47
ШТА-ГА

Мөрөн сум

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Мөрөн хотын тохижилт үйлчилгээний үйл ажиллагаа, санхүүжилт, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны А/14, А/16 дугаар тушаалаар байгуулсан үнэлгээний хороо нь ирүүлсэн тендерийг үнэлсэн талаар баримт бичиг үйлдээгүй, захиалагчид гэрээ байгуулах эрх олгох талаар зөвлөмж өгөөгүй, тендерийн баримт бичгийг хуулийн дагуу архивын нэгж болгон хадгалаагүй бөгөөд Tender.gov.mn цахим системд тендерийн эцсийн үр дүнг бүрэн оруулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дор дурдсан чиг үүрэгтэй байна: 47.2.1 “техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх”, 47.2.2 “тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх. Уг шийдвэрийг энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан үндэслэлгүйгээр өөрчлөхийг хориглоно”, 49 дүгээр зүйлийн 49.1 “Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргаасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.9-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2022 оны А/14, 2023 оны А/14 дүгээр тушаалаар байгуулсан үнэлгээний хорооны дарга болон гишүүдэд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 01 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлэхийг “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Мөнх-Эрдэнэд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Г.ИЧИНХОРЛОО

Монгол Улс, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байр 3 давхар 302 тоот